



ШҮҮХИЙН СУРГАЛТ,  
СУДАЛГАА,  
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

ШҮҮГЧИЙГ ТАТГАЛЗАН ГАРГАХ  
ХҮСЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ  
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН  
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2022/14/32

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ  
2022.11.25

## ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	3
УДИРТГАЛ .....	4
НЭГ. ШҮҮГЧИЙН ТАТГАЛЗАН ГАРГАХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ .....	5
ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА .....	9
ДҮГНЭЛТ .....	26
ЭХ СУРВАЛЖ .....	29

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>АНУ</b>	Америкийн Нэгдсэн Улс
<b>БНЛУ</b>	Бүгд Найрамдах Латви Улс
<b>БНСУ</b>	Бүгд Найрамдах Солонгос Улс
<b>ИПХ</b>	Иргэний Процессын хууль
<b>ИХХША</b>	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
<b>ИХШХШТХ</b>	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
<b>ОХУ</b>	Оросын Холбооны Улс
<b>ХБНГУ</b>	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
<b>ЭПХ</b>	Эрүүгийн Процессын хууль
<b>ЭХХША</b>	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
<b>ЭХХШТХ</b>	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

## УДИРТГАЛ

### Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд иргэний болон эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “шүүгчийн татгалзан гаргах”-тай холбоотой гадаад улсын эрх зүйн зохицуулалт, тус эрх зүйн хэм хэмжээний зорилго, “шүүгчээс татгалзах үндэслэл”-ийн хүрээ, түүний үр дагавар, тус хүсэлтийг хэрхэн шийдвэрлэдэг талаар харьцуулсан судлахад оршино.

### Судалгааны хамрах хүрээ

Судлах зүйлийн хүрээнд ХБНГУ, Япон Улс, БНСУ, АНУ, ОХУ, БНЛУ-ыг сонгон авч, харьцуулсан судалгаанд хамруулсан болно.

### Судалгааны арга зүй

Судалгааг хийж хийж гүйцэтгэхдээ харьцуулан судлах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглав.

### Судалгааны бүтэц

Тус судалгаа нь Шүүгчийн татгалзан гаргах тухай ерөнхий ойлголт, Харьцуулсан судалгаа, Дүгнэлт, Эх сурвалж гэсэн хэсгээс бүрдэнэ.

## НЭГ. ШҮҮГЧИЙН ТАТГАЛЗАН ГАРГАХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Шүүгч нь хэрэг, маргааныг хувийн эсхүл аливаа бусад ашиг сонирхлын үүднээс бус, хууль болон нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлэхдээ хараат бус, зарчимч, шударга байж, төвийг сахих ёстой. Шүүгч ямар нэг хувийн ашиг сонирхол эсхүл ялгаварлан гадуурхах хандлагагүйгээр хуулиар хүлээсэн шүүн таслах, хэрэг хянан шийдвэрлэх үүргээ биелүүлэх бөгөөд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх талаарх ямар нэгэн урьдчилсан хандлагаас чөлөөлөгдөж, түүнээс ямагт ангид байж шийдвэрээ гаргадаг байх үүрэг хүлээдэг. Учир иймд шүүгчийн биелүүлэх ёстой хараат бус, зарчимч, шударга байх, төвийг сахих зарчимтай зөрчилдөх эсхүл тийнхүү ойлгогдох нөхцөл байдал бий болсон тохиолдол бүрд шүүгч тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд оролцож болохгүй.<sup>1</sup>

Тухайлбал энэхүү харилцаанд гол эх сурвалж болж буй хуулийн зохицуулалтыг доорх байдлаар үзүүлбэл:

<b>Үндсэн хууль</b>	Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 “Шүүгч <b>хараат бус байж</b> , гагцхүү хуульд захирагдана”, 2 “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч <b>шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй</b> ” гэжээ.
<b>Шүүгчийн Ёс Зүйн Талаарх Бангалорын Зарчмуудын Тайлбар<sup>2</sup></b>	<b>6.7. Шүүгч нь шүүх эрх мэдлийг зохистойгоор хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаанд оролцож болохгүй.</b> <b>Шүүгч хэргээс татгалзан гарах</b> 217. Ашиг сонирхлын зөрчил, ноцтой өвчин зэрэг үндэслэл бүхий шалтгаангүйгээр, хэргээс тухайн шүүгчийг татгалзан гаргаж болохгүй. <b>Шүүгчийг татгалзан гаргах аливаа тийм үндэслэл журмыг хууль буюу шүүхийн журмаар зохицуулах ёстой.</b> Шүүхийн чиг үүргийн гүйцэтгэлийг хангах үүднээс олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, хуульд нийцсэн үйлдэл хийхээс бусдаар гадаадын бусад эрх мэдэл, гүйцэтгэх засаглалаас аливаа байдлаар шүүгчид нөлөөлөх ёсгүй.
<b>Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль /2021 онд хүчингүй болсон/</b>	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 “Шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол <b>оролцохоос татгалзах</b> , эсхүл уг болзошгүй нөхцөл байдал үүсэж болохыг шүүх ажиллагаанд оролцогчдод мэдэгдэж, тэдгээрийн <b>татгалзан гаргах санал тавих боломжийг хангах үүрэгтэй</b> ”.
<b>ИХШХШТХ</b>	91.1.Шүүгч дараах үндэслэл байвал хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй: 91.1.1.урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, иргэдийн төлөөлөгч,

<sup>1</sup> Шүүгчийн ёс зүй (сургалтын гарын авлага), Шүүхийн Ерөнхий Зөвлөл, УБ 2018 он., 57 дахь тал. [http://khamtdaa.mn/media/khamtdaa/content/%D0%90%D0%B7%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D0%B0%D0%BD/%D0%9C%D1%8D%D0%B4%D0%BB%D1%8D%D0%B3%D0%B8%D0%B8%C%D0%86%D0%BD%20%D1%81%D0%B0%D0%BD/%D0%93%D0%B0%D1%80%D1%8B%D0%BD\\_%D0%B0%D0%B2%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0-%D0%A8%D2%AF%D2%AF%D0%B3%D1%87%D0%B8%D0%B9%D0%BD\\_%D1%91%D1%81\\_%D0%B7%D2%AF%D0%B9\\_20180927.pdf](http://khamtdaa.mn/media/khamtdaa/content/%D0%90%D0%B7%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D0%B0%D0%BD/%D0%9C%D1%8D%D0%B4%D0%BB%D1%8D%D0%B3%D0%B8%D0%B8%C%D0%86%D0%BD%20%D1%81%D0%B0%D0%BD/%D0%93%D0%B0%D1%80%D1%8B%D0%BD_%D0%B0%D0%B2%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0-%D0%A8%D2%AF%D2%AF%D0%B3%D1%87%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%91%D1%81_%D0%B7%D2%AF%D0%B9_20180927.pdf) (Сүүлд үзсэн: 2022.11.21).

<sup>2</sup> Шүүгчийн Ёс Зүйн Талаарх Бангалорын Зарчим (2002), Түүний Тайлбар (2007), *НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба*, <http://khamtdaa.mn/media/khamtdaa/content/%D0%90%D0%B7%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D0%B0%D0%BD/%D0%9C%D1%8D%D0%B4%D0%BB%D1%8D%D0%B3%D0%B8%D0%B8%C%D0%86%D0%BD%20%D1%81%D0%B0%D0%BD/Bangalor.pdf> (Сүүлд үзсэн: 2022.11.21).

	<p>шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн хувиар оролцсон;</p> <p>91.1.2.уг хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн гэр бүл, төрөл, садан бол, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн болон төрөл, садны холбоотой хүмүүс орсон байвал;</p> <p>91.1.3.хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн <b>уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;</b></p> <p>91.1.4.<b>ашиг сонирхлын зөрчил</b> үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол.</p> <p>91.2.<b>Энэ хуулийн 84 дүгээр зүйл, 91.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно.</b></p>
<p><b>ЭХХШТХ</b></p>	<p><b>10.1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч оролцож болохгүй үндэслэл</b></p> <p>1.Шүүгч дараах үндэслэл байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй:</p> <p>1.1.оролцогчийн хувиар тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа, эсхүл оролцохоор бол;</p> <p>1.2.тухайн хэргийн прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүн бол;</p> <p>1.3.өмнө нь тухайн хэрэгт прокурор, мөрдөгч, оролцогч, бусад оролцогч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцсон бол;</p> <p>1.4.<b>өөрөө шууд, эсхүл шууд бусаар энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.</b></p> <p>2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн гишүүн, төрөл, садны холбоотой шүүгч оролцож болохгүй.</p> <p>3.Анхан шатны шүүх бүрэлдэхүүнд орсон шүүгчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүн уг хэргийг давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд орж болохгүй.</p> <p>4.Шүүгч энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3-т заасан үндэслэлийг мэдмэгц эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үүрэгтэй ба уг үүргээ биелүүлээгүй бол гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгоно.</p> <p><b>10.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл</b></p> <p>1.Эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.</p> <p>2.Энэ хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах этгээдээр тогтоосон шийдвэр гаргасан шүүгч уг хүний үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.</p> <p>3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүгчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садны холбоотой шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.</p> <p><b>10.3 дугаар зүйл.Шүүгчийг татгалзан гаргах</b></p> <p>1.Энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах тухай хүсэлтийг <b>прокурор, оролцогч гаргаж болно.</b></p> <p>2.Шүүгчийг татгалзан гаргах асуудлыг <b>шүүх хуралдаан эхлэхээс өмнө шийдвэрлэнэ.</b> Шүүх хуралдаан эхэлснээс хойш татгалзан гаргах үндэслэл мэдэгдвэл уг хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө гаргаж болно.</p> <p><b>10.4 дүгээр зүйл.Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хянан шийдвэрлэх</b></p> <p>1.Хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр <b>татгалзвал шүүгч шүүх хуралдааныг хойшлуулж, уг асуудлыг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.</b></p>

	<p>2.Ерөнхий шүүгчийг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж шийдвэрлүүлнэ.</p> <p>3.Шүүх бүрэлдэхүүний аль нэг шүүгчийг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд шийдвэрлэж, санал тэнцвэл уг шүүгчийг татгалзсанд тооцно.</p> <p>4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүгчийг байлцуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх боловч татгалзагдаж байгаа шүүгч уг асуудлын талаар шүүх бүрэлдэхүүнд тайлбар гаргаж болно.</p> <p>5.Шүүх бүрэлдэхүүний олонхийг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзсан бол уг асуудлыг шүүх хуралдаан даргалагч тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.</p> <p>6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу татгалзан гаргах шүүх бүрэлдэхүүнд Ерөнхий шүүгч багтаж байгаа, эсхүл нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан тохиолдолд энэ тухай тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж шийдвэрлүүлнэ.</p> <p>7.Ерөнхий шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх шүүгчдийн зөвлөгөөнд Ерөнхий шүүгч уг асуудлын талаар тайлбар гаргаж болох боловч санал өгөх эрхгүй.</p> <p>8.Энэ зүйлийн 1, 2, 3, 5, 6 дахь хэсэгт заасан үндэслэлээр гаргасан шийдвэр эцсийн байна.</p> <p>9.Хяналтын шатны шүүхийн хувьд энэ зүйлийн 1, 2, 5, 6 дахь хэсэгт заасан асуудлыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>
<p><b>Шүүгчийн ёс зүйн дүрэм</b></p>	<p>Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 2 “Хэргийн оролцогчийн зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээрээ бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ” гэж зохицуулсан.</p>

Шүүгч хуулиар хүлээсэн шүүгчийн албаны чиг үүргээ бодитой, шударга, төвийг сахиж, хараат бусаар гүйцэтгэхэд нь саад учруулах **үндэслэл бүхий эргэлзээ** байвал тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана. Энэ ерөнхий зарчмаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах тохиолдлуудыг процессын хуулиудын дээрх дурдсан зүйл заалтуудаар зохицуулж өгсөн байна.<sup>3</sup>

<sup>3</sup> Шүүгчийн ёс зүй (сургалтын гарын авлага), Шүүхийн Ерөнхий Зөвлөл, 2018 он., 60 дахь тал.

Үүнээс гадна Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд<sup>4</sup> хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах татгалзлын талаар процессын хуулиудад зааснаас илүү нарийвчлан дэлгэрүүлж зохицуулсан байдаг.<sup>5</sup>

Өөрөөр хэлбэл шүүгч нь тухайн тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ашиг сонирхлын зөрчилтэй байдал илэрвэл хэрхэх, татгалзах эсэх талаар процессын хуулиудад ерөнхий байдлаар хуульчлан зохицуулсан байдаг бол Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд илүү нарийвчлан зохицуулсан байдаг. Тодруулбал, хамгийн илэрхий татгалзлын хэлбэрүүдийг хуульд тусгасан. Иймээс тухайн шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах бодитой нөхцөл, шүүгчийн ашиг сонирхлын зөрчилт байдал бий болсон эсэхийг шийдвэрлэх, дүгнэн шинжлэх ур чадвар, дадал зүйтэй байхын тулд гагцхүү процессын хуулиуд бус холбогдох бусад хууль эрхийн акт болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд уг харилцааг хэрхэн зохицуулсан байдаг болохыг судалж мэдсэн байх ёстой.<sup>6</sup>

АНУ-ийн Виржиниа мужид Хуульчдад ёс зүйн зөвлөгөө өгдөг хороо ажилладаг байна. Шүүгчид өөрт нь тухайн тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах ёстой эсэх, шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үнэхээр үүссэн эсэх, шүүгчийн ёс зүйн зөрчил болох эсэх талаар эргэлзээ төрж, өөрөө түүнийгээ шийдвэрлэж тодорхойлж чадахгүй байгаа тохиолдолд энэ асуудлыг шийдвэрлэдэг дээрх хороонд хандах боломж байдаг ажээ. Комисс нь эрдэмтэн, судлаачид, онолчид, хуульчийн ёс зүйгээр мэргэшсэн хуульчид, практикийн нарийн мэргэшсэн хуульчид буюу ёс зүйгээр мэргэшсэн шүүгч, өмгөөлөгч, профессор зэргээс бүрддэг.<sup>7</sup>

Ийнхүү шүүгчийг татгалзсан гаргасны үр дагавар хэргийг шилжүүлэх ойлголттой уялддаг. Хэргийг шийдвэрлэх шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргаснаар хэргийг тал бүрээс нь бодитой шийдвэрлэхийн тулд нотлох баримтын дийлэнх байгаа газрын харьяа

<sup>4</sup> 16 дугаар бүлэг. Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил, дэлгэрэнгүй дурдвал:

**16.1 дүгээр зүйл. Хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах ерөнхий нөхцөл**

1. Шүүгч хуулиар хүлээсэн шүүгчийн үүргээ бодитой, шударга, төвийг сахиж гүйцэтгэхэд нь саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана.

2. Шүүгч дараах нөхцөл үүссэн тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:  
2.1. шүүгч өөрөө эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээд тухайн маргаантай асуудалд эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг талтай хувийн ашиг сонирхлоор холбоотой гэдгийг мэдэж байгаа;  
2.2. тухайн хянан шийдвэрлэх ажиллагааны асуудлын талаар тодорхой үр дүнд хүрнэ, шийдвэр гаргана гэж олон нийтэд мэдээлсэн эсхүл олон нийтэд тийм ойлголт төрүүлсэн.

**16.2 дугаар зүйл. Хянан шийдвэрлэх ажиллагааны оролцооноос шалтгаалж татгалзах**

1. Шүүгч нь өөрөө эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нь дараах этгээдийн аль нэг гэдгийг мэдсэн бол тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

- 1.1. хэрэг, маргааны оролцогч, эсхүл түүний шууд удирдах албан тушаалтан;
- 1.2. хуульчаар оролцож байгаа;
- 1.3. гэрчээр оролцох.

**16.3 дугаар зүйл. Урьд нь гүйцэтгэж байсан үүргээс хамаарч татгалзах**

1. Шүүгч урьд нь тухайн хэрэг, маргаантай холбогдуулан дараах үүргийн аль нэгийг гүйцэтгэж байсан бол хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

- 1.1. хуульчаар оролцож байсан, эсхүл нэг өмгөөллийн нөхөрлөлд ажиллаж байсан бусад хуульч нь тухайн асуудалд голлох үүрэгтэй оролцсон;
- 1.2. хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн албан хаагчийн хувиар оролцсон эсхүл тухайн асуудлын талаар төрийн албан хаагчийн хувьд байр сууриа олон нийтэд илэрхийлж байсан;
- 1.3. гэрчийн мэдүүлэг өгч байсан;
- 1.4. хянан шийдвэрлэхэд шүүгчээр оролцож байсан.

<https://www.mglbar.mn/assets/media/uploads/7qsjsqi7qe.pdf> (Сүүлд үзсэн: 2022.11.22).

<sup>5</sup> Шүүгчийн ёс зүй (сургалтын гарын авлага), Шүүхийн Ерөнхий Зөвлөл, 2018 он., 60 дахь тал.

<sup>6</sup> Мөн тэнд, Эшлэл 5.

<sup>7</sup> Мөн тэнд, Эшлэл 3. 60-61 дэх тал.

шүүхэд шийдвэрлэх шаардлага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрдэг. Энэ тохиолдолд хэрэг шилжүүлэх ажиллагааг шүүх өөрийн болон зохигчдын хүсэлтээр анхан шатны шүүх хуралдаанаас өмнө буюу хуралдааны явцад гүйцэтгэх боломжтой ба шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.<sup>8</sup>

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үүссэн шүүгчийг татгалзан гаргахтай холбоотой асуудлыг бусад гадаад улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд (иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох хэм хэмжээний хүрээнд) хэрхэн зохицуулсныг дараах бүлэгт дурдав.

## ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

### 1. ХБНГУ

ХБНГУ-ын ИПХ болон ЭПХ нь 1877 онд батлагдсан тул тус хуулиудад тусгагдсан “шүүгчийг татгалзан гаргах үндэслэл” болон эрх зүйн зохицуулалт нь хоорондоо ихээхэн төстэй.

Шүүгчийн татгалзан гаргах зохицуулалтыг:

- Шүүгчийг гаргах (Ausschluss) болон
- Шүүгчээс татгалзах (Ablehnung) гэж хоёр ангилж болно.

#### а) Шүүгчийг гаргах (Ausschluss)

Шүүгчийг гаргах (Ausschluss) зохицуулалт нь практикт хамгийн түгээмэл тохиолддог кейсүүдийг жагсаан хуульчлахын зэрэгцээ, шүүгчийг хэргээс гаргах шууд үр дагаврыг тусгасан байдаг.

ИПХ-ийн зохицуулалт	ЭПХ-ийн зохицуулалт
<p>ИПХ-ийн 41 дүгээр зүйл. <i>Дараах тохиолдолд шүүгчийг хэргээс гаргана:</i></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүгч тухайн хэргийн оролцогч байх, эсхүл тухайн хэргийн оролцогчийн аль нэг талтай хамтран эрх, үүрэг, хариуцлага хүлээх этгээд байх тохиолдол;</li> <li>2. Шүүгчийн эхнэр/нөхөр (өмнөх эхнэр/нөхөр) тухайн хэргийн оролцогч байх;</li> <li>2а. Шүүгчийн хамтран амьдрагч (өмнөх хамтран амьдрагч) тухайн хэргийн оролцогч байх;</li> <li>3. Шүүгч тухайн хэргийн оролцогчтой цусан төрлийн, гэр бүлийн холбоотой байх, эсхүл 3 дах үеийн төрөл садан, эхнэр/нөхөр-ийн 2 дах үеийн төрөл садан байх тохиолдол;</li> <li>4. Шүүгч тухайн хэргийн оролцогчийн өмгөөлөгчөөр томилогдсон байх, эсхүл туслалцаа үзүүлэх этгээд байх, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч байх тохиолдол;</li> <li>5. Шүүгч тухайн хэргийн гэрч эсхүл шинжээч байх тохиолдол;</li> <li>6. Шүүгч тухайн хэргийн өмнөх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд туслалцаа үзүүлсэн байх, оролцсон байх;</li> <li>7. Шүүгч тухайн хэргийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа болон маргааныг шийдвэрлэх алтернатив ажиллагаанд туслалцаа үзүүлсэн тохиолдол.</li> </ol>	<p>ЭПХ-ийн 22 дугаар зүйл. <i>Дараах тохиолдолд шүүгчийг гаргана:</i></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүгч тухайн гэмт хэргийн хохирогч байх тохиолдол;</li> <li>2. Шүүгч эсхүл түүний эхнэр/нөхөр, хамтран амьдрагч нь тухайн хэргийн хохирогч эсхүл яллагдагч байх, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч байх тохиолдол;</li> <li>3. Шүүгч тухайн хэргийн хохирогч эсхүл яллагдагчтай төрөл садан, гэр бүлийн харилцаатай байх, эсхүл 3 дах үеийн төрөл садан, эхнэр/нөхөр-ийн 2 дах үеийн төрөл садан байх тохиолдол;</li> <li>4. Шүүгч тухайн хэргийн хохирогчийн өмгөөлөгч, хуульч байх, эсхүл тухайн хэргийн мөрдөгч, прокуророор ажилласан байх тохиолдол;</li> <li>5. Шүүгч тухайн хэргийн гэрч эсхүл шинжээчээр томилогдсон тохиолдол.</li> </ol>

<sup>8</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй (гарын авлага), 2007 он., 77-78 дахь тал.

Шүүгчийг гаргах дээрх үндэслэлүүдийг 1) Хувийн ашиг сонирхол; 2) Гэр бүл, хувийн харилцаа; 3) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байх гэсэн гурван төрөлд хуваан ойлгох боломжтой<sup>9</sup>.

Тус улсын хуульд “шүүгчийг гаргах” үндэслэлүүдийг тоочсон байх ба шүүгчийг гаргах (Ausschluss) дээрх үндэслэлүүд нь хаалттай жагсаалт (хуульд заасан эдгээр үндэслэлээс бусад өөр үндэслэлээр шүүгчийг гаргаж үл болно гэсэн агуулгатай императив хэм хэмжээ гэж ойлгож болно) тул, дээрх үндэслэлүүдийг дэлгэрэнгүй, нээлттэй (зохицуулалтын агуулгыг өргөн хүрээнд) тайлбарлахыг хориглодог бөгөөд аль болох явцуу хүрээнд тайлбарлах нь зүйтэй гэж үздэг<sup>10</sup> байна.

#### **b) Шүүгчээс татгалзах (Ablehnung)**

Шүүгчээс татгалзах (Ablehnung) үндэслэл нь шүүгчийг гаргах үндэслэлд хамаарахааргүй боловч шүүгчийн шударга, хараат бус байдалд нөлөө үзүүлж болзошгүй бусад тохиолдлуудыг зохицуулах замаар шүүгчийг гаргах үндэслэлүүдийг нөхөж байдаг<sup>11</sup>. Үүнийг доорх байдлаар харуулбал:

ИПХ-ийн зохицуулалт	ЭПХ-ийн зохицуулалт
<p>ИПХ-ийн 42 дугаар зүйл.</p> <p>1. Шүүгчийг гаргах шаардлагатай тохиолдолд эсхүл <b>шүүгч хэргийн талаар өрөөсгөл ойлголттой байна гэсэн айдастай (fear of bias)</b> байх тохиолдолд шүүгчээс татгалзаж болно.</p> <p>2. Шүүгч хараат бусаар хэргийг шийдвэрлэж чадахгүй гэсэн эргэлзээ эвтгөх тодорхой үндэслэлүүд байх тохиолдлыг <b>шүүгч хэргийн талаар өрөөсгөл ойлголттой байна гэсэн айдастай (fear of bias)</b> байх тохиолдол гэж ойлгоно.</p>	<p>ЭПХ-ийн 24 дүгээр зүйл.</p> <p>1. Шүүгчийг гаргах шаардлагатай тохиолдолд эсхүл <b>шүүгч өрөөсгөл ойлголттой байна гэсэн айдастай (fear of bias)</b> байх тохиолдолд шүүгчээс татгалзаж болно.</p> <p>2. Шүүгчийн хараат бус байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл байх тохиолдолд <b>шүүгч өрөөсгөл ойлголттой байна гэсэн айдастай (fear of bias)</b> байх үндэслэлээр шүүгчээс татгалзаж болно.</p>

Өөрөөр хэлбэл, субъектив урьдчилсан нөхцөлийн хүрээнд **шүүгч өрөөсгөл ойлголттой байна гэсэн айдастай (fear of bias)** байх тохиолдолд шүүгчээс татгалзаж болох бөгөөд түүнийг **шүүгчийн хараат бус байдалд үндэслэл бүхий эргэлзээ байгаа эсэх** хэмээх объектив шалгуураар тогтооно<sup>12</sup>.

Түүнчлэн, ХБНГУ-ын судлаачид шүүгчээс татгалзах (Ablehnung) зохицуулалтын зорилгын талаар “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа, доголдлыг хянах, засах явдал бус шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг хадгалах, хангах явдал” гэсэн ерөнхий тодорхойлолтыг өгдөг<sup>13</sup> бол шүүгчээс татгалзах үндэслэлийг явцуу хүрээнд тайлбарлах үүднээс тэргүүлэх судлаачид “шүүгчийн хараат бус байдалд эргэлзээ төрөхүйц хангалттай объектив үндэслэлүүд байх шаардлагатай” гэсэн тайлбарыг хийсэн байна<sup>14</sup>.

Дараах хэд хэдэн кейсүүдэд шүүгчээс татгалзах эсэх нь маргаан дагуулсан:

- 1) Үндсэн хуулийн шүүхийн шүүгч шүүхийн шийдвэр гарахаас өмнө тухайн асуудлын талаар олон нийтэд их сургуулийн профессорын хувиар мэдэгдэл хийсэн нь тухайн шүүгчээс **татгалзах үндэслэл болсон**<sup>15</sup>;

<sup>9</sup> Sigmund A. Cohn, *Judicial Recusation in the Federal Republic of Germany*, 3 Ga. J. INT'L & COMP. L. 18, 21 (1973).

<sup>10</sup> Peter Mezei & Emircan Karabuga, *Judicial Recusation in Germany and Turkey*, 3 Comparative Law Working Papers 2 (2019).

<sup>11</sup> *supra* note 9, 30.

<sup>12</sup> Sigmund A. Cohn, *supra* note 9, 31.

<sup>13</sup> Peter Mezei & Emircan Karabuga, *supra* note 10, 2.

<sup>14</sup> Sigmund A. Cohn, *supra* note 9, 31.

<sup>15</sup> Judgment of March 3, 1966 (BVerfG), *Neue Juristische Wochenschrift* 922 (1966).

- 2) Шүүхийн урьдчилсан шатанд шүүгч хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөхдөө тодорхой болоогүй үйл баримтыг нэгэнт тогтоогдсон үйл баримт мэтээр ярьсан нь шүүгчээс **татгалзах үндэслэл болсон**<sup>16</sup>.
- 3) Шүүгч нэг дүүрэгт харьяалагддаг өөр нэг шүүгчийн хариуцагчаар оролцсон хэргийг шүүх боломжтой эсэх нь маргаан дагуулсан ба тус тохиолдлын хувьд тухайн шүүгчдийн хоорондын харилцаа нь ажил хэргийн харилцаанаас цааш хэтрэхгүй тохиолдолд, энэ нь шүүгчээс **татгалзах үндэслэл болохгүй** гэж шийдвэрлэсэн<sup>17</sup>.
- 4) Тухайн хэргийн хууль зүйн асуудлын талаар эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн байх нь шүүгчээс **татгалзах үндэслэл болох боломжтой**<sup>18</sup>.
- 5) Шүүгч аливаа нэг улс төрийн нам болон үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх нь тухайн шүүгчээс **татгалзах үндэслэл болохгүй**<sup>19</sup>.
- 6) Шашны сүсэг бишрэл, үзэл санаа, хүйс, гэр бүлийн статус зэрэг нь шүүгчээс **татгалзах үндэслэл болохгүй**<sup>20</sup>.
- 7) Тухайн хэрэгт шүүгч болон прокурор/өмгөөлөгч нь нэг гэр бүлийн гишүүд буюу эхнэр/нөхөр байх нь тухайн шүүгчээс татгалзах үндэслэл болох эсэх нь асуудал дагуулдаг. Холбооны шүүх, иргэний хэрэгт шүүгч болон өмгөөлөгч нь эхнэр/нөхөр байх тохиолдолд тухайн шүүгч болон өмгөөлөгчийн санхүүгийн ашиг сонирхол холбоотой байх тул шүүгчээс **татгалзах үндэслэл болно** гэж шийдвэрлэсэн<sup>21</sup>.

## 2. Япон Улс

Япон Улсын Үндсэн хуульд шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах, түүнчлэн шүүх хэрэг маргааныг шударгаар шийдвэрлэх ерөнхий баталгааг хуульчилж өгсөн байдаг. Энэ утгаараа, ИПХ-д шүүгчийг гаргах (除斥), шүүгчээс татгалзах (忌避) тухай зохицуулсан.

### а. Шүүгчийг гаргах (除斥)

ИПХ-ийн зохицуулалт	ЭПХ-ийн зохицуулалт
ИПХ-ийн 23 дугаар зүйл. Шүүгчийг гаргах үндэслэл	ЭПХ-ийн 20 дугаар зүйл. Шүүгчийг гаргах үндэслэл
1. Шүүгч эсхүл түүний эхнэр/нөхөр (эсхүл өмнөх), тухайн хэргийн оролцогч байх эсхүл хэргийн оролцогчтой хамтран эрх үүрэг хүлээх эсхүл нөхөн төлбөр төлөх харилцаанд байх тохиолдол;	1. Шүүгч тухайн хэргийн хохирогч байх тохиолдол
2. Шүүгч тухайн хэргийн оролцогчийн 4 дөх үеийн цусан төрөл, 3 дахь үеийн төрөл садан байх эсхүл хамтран амьдардаг угсааны хүн байх эсхүл байсан тохиолдол;	2. Шүүгч тухайн хэргийн яллагдагч эсхүл хохирогчийн төрөл садан байх, эсхүл байсан тохиолдол
3. Шүүгч тухайн хэргийн оролцогчийн асран хамгаалагч, асран хамгаалалтыг хянагч, харгалзан дэмжигч, харгалзан дэмжигчийг хянагч, асрагч түүний хянагч байх тохиолдол	3. Шүүгч тухайн хэргийн яллагдагч эсхүл хохирогчийн төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнийг хянагч байх тохиолдол
4. Шүүгч тухайн хэргийн гэрч болсон эсхүл шинжээчээр томилогдсон тохиолдол;	4. Шүүгч тухайн хэргийн гэрч болсон эсхүл шинжээчээр томилогдсон тохиолдол
5. Шүүгч тухайн хэргийн оролцогчийн төлөөлөгч, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч байх эсхүл байсан тохиолдолд;	5. Шүүгч тухайн хэргийн яллагдагчийн төлөөлөгч, өмгөөлөгч эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч болсон тохиолдол
6. Шүүгч тухайн хэргийн арбитрын ажиллагаанд оролцсон, эсхүл тухайн	6. Шүүгч тухайн хэргийн прокурор эсхүл мөрдөгч байсан тохиолдол
	7. Шүүгч тухайн хэргийн өмнөх шатны шүүх эсхүл нотлох баримтыг бүрдүүлэх ажиллагаанд оролцсон тохиолдол

<sup>16</sup> Judgment of July 9, 1953, 4 BGHSt. 264.

<sup>17</sup> Judgment of July 4, 1957 (BGHZ), [19571 NJW 1400 (W. Ger. 1957)].

<sup>18</sup> Peter Mezei & Emircan Karabuga, *supra note* 9, 4.

<sup>19</sup> Peter Mezei & Emircan Karabuga, *supra note* 9, 4.

<sup>20</sup> Peter Mezei & Emircan Karabuga, *supra note* 9, 4.

<sup>21</sup> (2012) V ZB 102/11 (BGH 5th Zivilsenat) (Germany).

хэргийн өмнөх шатны шүүхийн ажиллагаанд оролцсон тохиолдол.	
---	--

Дээрх ИПХ-ийн 23 дугаар зүйлийн 1-ээс 3 дахь үндэслэл нь шүүгч хэргийн оролцогчтой ямар нэгэн хувийн харилцаа, холбоотой тохиолдлыг хуульчилсан бол 4-өөс 6 дахь үндэслэл нь шүүгч тухайн нэхэмжлэл, маргааны зүйлтэй ямар нэгэн холбоотой тохиолдлыг хуульчилсан байна<sup>22</sup>.

Шүүгчийг гаргах (除斥) үндэслэл байвал, шүүх талуудын хүсэлтээр эсхүл өөрийн санаачилгаар шүүгчийг гаргах асуудлыг шийдвэрлэнэ (ИПХ 23.2).

Шүүгчийг гаргах дээрх үндэслэлүүд байх тохиолдолд талууд хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран шүүгч шууд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болох бөгөөд шүүгчийн өмнө нь явуулсан аливаа процесс ажиллагаа анхнаасаа хүчин төгөлдөр бус байна.

Ийм төрлийн хүнд үр дагавартай тул дээрх үндэслэлүүдийг аль болох явцуу хүрээнд тайлбарлах нь зүйтэй гэж үздэг<sup>23</sup>.

#### б. Шүүгчээс татгалзах (忌避)

Дээр дурдсан “шүүгчийг гаргах” үндэслэлд хамаарахгүй боловч хэргийг хараат бус, шударгаар шүүх явдалд саад болохуйц бусад тохиолдлын хувьд ИПХ-ийн 24 дүгээр зүйл шүүгчээс татгалзах (忌避) явдлыг хуульчилсан.

ИПХ-ийн зохицуулалт	ЭПХ-ийн зохицуулалт
ИПХ-ийн 24.1 дүгээр зүйл. Тухайн шүүгчид хэргийг шударгаар шүүхэд саад болох нөхцөл байдал байх тохиолдолд, хэргийн оролцогч шүүгчээс татгалзаж болно.	21 дүгээр зүйл. Шүүгчийг гаргах шаардлагатай тохиолдолд эсхүл хэргийг шударгаар шийдвэрлэж чадахгүй гэсэн эргэлзээ байх тохиолдолд, прокурор эсхүл яллагдагч шүүгчээс татгалзаж болно.

Шүүгчээс татгалзах (忌避) үндэслэл нь **хэргийг шударгаар шүүхэд саад болох нөхцөл байдал** гэсэн ерөнхий, хийсвэр үндэслэл байх тул түүнийг тайлбарлах зайлшгүй шаардлага бий болдог. Үүнтэй холбоотойгоор тэргүүлэх судлаачдын зүгээс дараах нийтлэг тайлбаруудыг дэвшүүлсэн байдаг.

Судлаачийн нэр	Тайлбар
Ито Макото <sup>24</sup>	Шүүгч хараат бус, шударга байх ёстой хэдий ч бие даасан хувь хүн гэдэг утгаараа өөрийн гэсэн тодорхой үзэл санаа, итгэл үнэмшилтэй байх нь гарцаагүй бөгөөд тэрхүү үзэл санаа, итгэл үнэмшил нь хэргийг шийдвэрлэхэд нөлөө үзүүлэхийг үгүйсгэхгүй. Гэсэн хэдий ч, <b>тэрхүү хувь хүний үзэл санаа, итгэл үнэмшил нь Үндсэн хуулийн 76.3 дугаар зүйлээр хамгаалагдсан шүүгчийн Ухамсар (良心)-д хамаарах тул, хувь хүний үзэл санаа, итгэл үнэмшил гэдэг шалтгаанаар шүүгчийг татгалзан гаргаж болохгүй.</b> Харин шүүгч хэргийн оролцогчтой найрсаг эсхүл дайсагнасан харилцаатай байх, эсхүл нэхэмжлэлийн зүйлтэй ашиг сонирхол нь холбоотой байх, эсхүл тухайн хэрэг маргаантай өмнө нь ажил үүргийн хувиар холбогдож байсан зэрэг тохиолдлуудад хэргийг шударгаар шүүхэд саад болохуйц объектив нөхцөл байдал байна гэж үзэх боломжтой. Эдгээр нөхцөл байдлууд нь шүүгчийн ухамсар (良心) болон хууль тогтоомжийн хүрээнд хэргийг шударгаар шийдвэрлэхэд саад болох бөгөөд мөн <b>гадна талаас нь таньж мэдэх боломжтой нөхцөл байдлууд тул шүүгчээс татгалзах үндэслэл болно.</b>

<sup>22</sup> 伊藤眞『民事訴訟法』104頁（有斐閣 第6版 2018年）。

<sup>23</sup> 池田修＝前田雅英『刑事訴訟法講義』290頁（東京大学出版会 第6版 2018年）。

<sup>24</sup> 伊藤・前掲注（1）106頁。

Шиндо Кожи <sup>25</sup>	ИПХ-ийн 24.1-д тусгагдсан <b>шүүгчээс татгалзах үндэслэл гэдэгт шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадахгүй гэсэн үндэслэл бүхий эргэлзээ буюу шүүгч тухайн хэрэг маргаантай ямар нэгэн онцгой байдлаар холбогдсон объектив нөхцөл байдлыг ойлгоно.</b> Жишээ нь: шүүгч нэг талын хэргийн оролцогчид нөхөрсөг хандах өсөрхөх, эсхүл тухайн хэрэг маргаанд эдийн засгийн ашиг сонирхолтой байх, эсхүл тухайн хэрэг маргаанд өмнө нь шинжээчээр оролцож байсан зэрэг тохиолдлууд шүүгчээс татгалзах үндэслэлд хамаарна.
--------------------------	---

Дээрх тайлбаруудаас ерөнхийлөн авч үзвэл, 1) Хэргийн оролцогчид нөхөрсөг, дайсагнасан хандах; 2) Нэхэмжлэлийн зүйлтэй ашиг сонирхол нь холбогдох; 3) Тухайн хэрэг маргаанд өмнө нь ямар нэгэн байдлаар оролцож байсан тохиолдол нь ИПХ-ийн 24.1-ийн шүүгчээс татгалзах үндэслэлд хамаарахаар байна.

Мөн түүнчлэн, ИПХ-ийн хүрээнд **шүүгчээс татгалзах (忌避) үндэслэлд хамаарахгүй тохиолдлууд** шүүхийн жишгийн хүрээнд илүү тодорхой болсон байдаг. Тэдгээрээс дурдвал:

- 1) Хэргийн оролцогчийн нэг тал болон шүүгч өөр хэрэг маргаанд эсрэг талын хэргийн оролцогчид байх (神戸地決昭和 58・10・28 判時 1109 号 126 頁);
- 2) Шүүгч тухайн хэргийн нэг талын оролцогчийн хүргэн байх (最判昭和 30・1・28 民集 9 卷 1 号 83 頁);
- 3) Төрөөс хохирлын нөхөн төлбөр шаардах маргаан (国家賠償)-д тухайн хэргийг хариуцаж авсан шүүгч өмнө нь хууль зүйн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн албыг хашиж байсан буюу төрийг төлөөлж байсан тохиолдол (名古屋高決昭和 63・7・5 判 夕 669 号 270 頁).

Харин ЭПХ-ийн **хүрээнд шүүгчээс татгалзах үндэслэлд хамаарахгүй** гэж үздэг шүүхийн жишгийг дурдвал:

- 1) Шүүгч тухайн хэргийн гэмт хэргийн хамтран үйлдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдаанд оролцсон тохиолдол (最決昭和 36・6・14 刑集 15・6・974);
- 2) Шүүгч тухайн хэргийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон тохиолдол (最決昭和 31・9・25 刑集 10・9・1382);
- 3) Шүүгч тухайн хэргийн эрх зүйн асуудлын талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн, илтгэл тавьсан тохиолдол (最大決昭和 47・7・1 刑集 26・6・355);
- 4) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамж, чиглэл (最決昭和 48・10・8 刑集 27・9・1415).

**Хэргийг шударгаар шийдвэрлэж чадахгүй гэсэн эргэлзээ байх тохиолдол гэдэгт талуудын субъектив үнэлэмжийг бус харин шүүгчийг гаргах (除斥) үндэслэлтэй төсөөтэй буюу объектив нөхцөл байдлыг ойлгоно**<sup>26</sup>. Тухайлбал, шүүгч хэргийн оролцогчийн аль нэг талтай онцгой харилцаанд байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүйгээр хэргийн талаарх дүгнэлтийг аль хэдийн дотроо хийсэн байх зэрэг нөхцөл байдал үүнд хамаарна<sup>27</sup>. Тийм ч учраас, **шүүгчийг гаргах үндэслэлтэй төсөөтэй байдлаар аль болох явцуу хүрээнд тайлбарлах шаардлагатай**<sup>28</sup>.

<sup>25</sup> 新堂幸司『新民事訴訟法』87 頁 (弘文堂 第 6 版 2019 年)。

<sup>26</sup> 池田 = 前田・前掲注 (9) 291 頁。

<sup>27</sup> 池田 = 前田・前掲注 (9) 291 頁参照。

<sup>28</sup> 池田 = 前田・前掲注 (9) 291 頁。

Шүүгчээс татгалзах хүсэлтийг аль болох хэргийн эхэн үе шатанд гаргах шаардлагатай<sup>29</sup>. Мөн түүнчлэн үндэслэлгүй хүсэлт гэдэг нь илэрхий тохиолдолд зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах зорилгоор тухайн хүсэлтийг гаргасан гэж үзээд хэрэгсэхгүй болгох боломжтой (ЭПХ 24.1, 簡易却下).

Судлаачид дээрх шүүхийн жишгүүдийг шүүгчээс татгалзах үндэслэлийг хэт явцуу хүрээнд тайлбарласан гэж санал нэгтгэйгээр шүүмжилдэг<sup>30</sup>.

Харин, **шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамж, чиглэл нь шүүгчээс татгалзах үндэслэлд хамаарахгүй** гэдэгт судлаачид болон шүүхийн жишиг санал нэгддэг<sup>31</sup> байна.

Цаашилбал, шүүгчээс татгалзах хүсэлтийг урвуулан ашиглах (濫用) тохиолдол байдаг. Өөрөөр хэлбэл, зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулах зорилгоор ямар ч үндэслэлгүйгээр шүүгчээс татгалзах хүсэлтийг дахин дахин гаргах явдлыг **шүүгчээс татгалзах хүсэлтийг урвуулан ашиглах (濫用)** гэж ойлгодог. Шүүгчээс татгалзах хүсэлтийг урвуулан ашиглах явдалтай тэмцэх 2 арга зам бий. Нэгдүгээрт, шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох шаардлагатай байдаг хэдий ч (ИПХ 26), шүүгч шүүгчээс татгалзах хүсэлтийг урвуулан ашиглаж байна гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоохгүй байх боломжтой<sup>32</sup>. Тухайн хүсэлт нь ямар ч үндэслэлгүй гэдэг нь илэрхий тохиолдолд энэ арга замыг сонгох нь зүйтэй гэж үздэг<sup>33</sup>. Хоёрдугаарт, тухайн шүүгч өөрөө хүсэлтийг шууд хэрэгсэхгүй болгох боломж (簡易却下)<sup>34</sup> юм.

### 3. БНСУ

<p><b>ИПХ-ийн зохицуулалт</b></p>	<p><b>2 ДУГААР БҮЛЭГ. ШҮҮГЧИЙГ СОЛИХ, ӨӨРЧЛӨХ БОЛОН ХОРИГЛОХ</b></p> <p><b>41 дүгээр зүйл. (Хориглох үндэслэл)</b> Шүүгч дараах үндэслэл байвал хэрэг хянан шийдвэрлэхэд оролцохыг нь хориглоно:</p> <p>(1) Шүүгч түүний эхнэр, нөхөр, болон түүний гэрэлтээ цуцалсан эхнэр /нөхөр/ нь хэргийн оролцогч болсон, эсвэл хэргийн оролцогчтой хамтран зээл олгогч, хамтран зээлдэгч, зээл хамтран төлөх үүрэгтэй бол;</p> <p>(2) Шүүгч нь хэргийн оролцогчтой ураг төрлийн холбоотой бол;</p> <p>(3) Шүүгч хэргийн талаар гэрчийн мэдүүлэг, хөрөнгийн үнэлгээ гаргаж байсан бол;</p> <p>(4) Шүүгч өмнө нь хэргийн оролцогчийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан тохиолдол;</p> <p>(5) Шүүгч өмнөх шатны шүүх хуралдаанд оролцсон бол: Өөр шүүхийн даалгаврын дагуу үүргээ гүйцэтгэсэн тохиолдолд хамаарахгүй.</p> <p><b>42 дугаар зүйл (Татгалзах тухай шийдвэр гаргах)</b> Шүүгчээс татгалзах үндэслэл байгаа тохиолдолд <b>шүүгчийн хүсэлтээр эсвэл хэргийн оролцогч этгээдийн хүсэлтээр татгалзах тухай шийдвэр гаргана.</b></p> <p><b>43 дугаар зүйл (Хэргийн оролцогчийн татгалзал гаргах эрх)</b></p> <p>(1) <b>Шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байгаа тохиолдолд хэргийн оролцогч талууд шүүгчээс татгалзал гаргаж болно.</b></p> <p>(2) <b>Хэргийн үндэслэлийн талаар шүүгчээс татгалзах шалтгаан байгаа бол хэргийн оролцогч тал мэдэж байж урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл</b></p>
-----------------------------------	---

<sup>29</sup> 池田 = 前田・前掲注 (9) 290 頁。

<sup>30</sup> 伊藤・前掲注 (1) 107 頁参照。

<sup>31</sup> 伊藤・前掲注 (1) 108 頁参照。

<sup>32</sup> 伊藤・前掲注 (1) 110 頁参照。

<sup>33</sup> 伊藤・前掲注 (1) 110 頁参照。

<sup>34</sup> 伊藤・前掲注 (1) 110 頁参照。

	<p><b>ажил) үеэр хүсэлт, мэдүүлэг өгсөн бол шүүгчээс татгалзал гаргах эрхгүй болно.</b></p> <p><b>44 дүгээр зүйл (Шүүх бүрэлдэхүүнээс татгалзах, хориглох талаар шийдвэр гаргах)</b></p> <p>(1) Шүүгчийг хориглох, татгалзах хүсэлтийг үндэслэлийг тодруулж шүүх бүрэлдэхүүн шүүгчийг хориглох, эсвэл татгалзах тухай хүсэлтийг шийдвэрлэнэ.</p> <p>(2) Шүүгчээс татгалзах эсвэл шүүгчийг хориглох талаарх шалтгаан, тайлбарыг хүсэлт гаргаснаас хойш гурав хоногийн дотор хариуг бичгээр гаргана.</p> <p><b>45 дугаар зүйл (Шүүгчээс татгалзах, хориглох шийдвэр гаргахаас татгалзах)</b></p> <p>(1) Шүүгчээс татгалзах, хориглох хүсэлт нь 44 дүгээр зүйлийн заалтыг зөрчсөн, эсвэл шүүх ажиллагааг хойшлуулах зорилготой байгаа нь илт бол, хүсэлтийг хүлээн авсан шүүх, шүүгч захирамжаар татгалзана.</p> <p>(2) (1)-д хамаарах тохиолдлоос бусад тохиолдолд шүүгчээс татгалзах, хориглох тухай хүсэлт гаргасан аливаа шүүгч нь хориглох, татгалзах хүсэлтийн талаар саналаа бичгээр нэн даруй танилцуулна.</p> <p><b>46 дугаар зүйл (Шүүгчээс татгалзах, хориглох хүсэлтийн тухай шийдвэр)</b></p> <p>(1) Шүүгчээс татгалзах, хориглох тухай хүсэлтийн шийдвэрийг тухайн шүүгчийн харьяалагддаг шүүхийн бүрэлдэхүүний захирамжаар гаргана.</p> <p>(2) Шүүгчээс татгалзах, хориглох хүсэлт гаргасан аливаа шүүгч (1)-д заасан шийдвэрт оролцохгүй.</p> <p>(3) Шүүгчийн харьяалагдах шүүх бүрэлдэхүүнээс шүүгчийг татгалзах, хориглох, хүсэлт гаргасан шүүгчдийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэх боломжгүй тохиолдолд шууд дээд шатны шүүх шийдвэрлэнэ.</p> <p><b>47 дугаар зүйл (Давж заалдах гомдол)</b></p> <p>(1) Шүүгчээс татгалзах, хориглох хүсэлтийг үндэслэлтэй гэж үзсэн шийдвэрийг давж заалдах эрхгүй.</p> <p>(2) 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу татгалзсан шийдвэрийн эсрэг, эсвэл шүүгчээс татгалзах, хориглох хүсэлтийг үндэслэлгүй гэж үзвэл нэн даруй давж заалдах гомдол гаргаж болно.</p> <p>(3) 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан татгалзсан шийдвэрт нэн даруй давж заалдах нь хэргийг түдгэлзүүлэхгүй.</p> <p><b>48 дугаар зүйл (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)</b></p> <p>(1) Шүүгчээс татгалзах, хориглох тухай хүсэлт гаргасан тохиолдолд уг хүсэлтийн шийдвэр эцсийн шийдвэр гарах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.</p> <p>(2) Хэрэв шүүгчээс татгалзах, хориглох хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан, эцсийн шүүхийн шийдвэр, хойшлуулшгүй ажиллагаа шаардсан тохиолдолд хамаарахгүй.</p> <p><b>49 дүгээр зүйл (Шүүгчийг өөрчлөх)</b></p> <p>41, 43 дугаар зүйлд хамаарах үндэслэл байгаа тохиолдолд эрх бүхий шүүх бүрэлдэхүүний зөвшөөрлөөр шүүгчийг өөрчилж болно.</p> <p><b>50 дугаар зүйл (Шүүхийн захиргааны байгууллагын ажилтныг хориглох, татгалзах, өөрчлөх)</b></p> <p>(1) Энэ хэсгийн заалтууд шүүхийн захиргааны байгууллагын ажилтанд дээрх зохицуулалтыг төсөөтэй хэрэглэнэ.</p> <p>(2) (1)-д заасны дагуу захиргааны байгууллагын ажилтныг хориглох, эсвэл татгалзсан тухай шүүхийн шийдвэрийг тухайн албан тушаалтны хамаарах шүүхийн шийдвэрээр гаргана.</p>
<p><b>ЭПХ-ийн зохицуулалт</b></p>	<p><b>2 ДУГААР БҮЛЭГ. ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, ШҮҮГЧИЙГ ХОРИГЛОХ ТАТГАЛЗАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ</b></p> <p><b>17 дугаар зүйл (Хориглох үндэслэл)</b></p> <p>Шүүгч дараах үндэслэл байвал хэрэг хянан шийдвэрлэхэд оролцохыг нь хориглоно:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүгч өөрөө хохирогч болсон;</li> <li>2. Хэргийн яллагдагч, хохирогчийн хамаатан садан, эсвэл ураг төрлийн холбоотой бол;</li> <li>3. Хэргийн яллагдагч, хохирогчийн асран хамгаалагч, эсвэл хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж байгаа бол;</li> <li>4. Хэргийн талаар гэрч, шинжээч хийж байсан, эсвэл хохирогчийн төлөөлөгч байсан бол;</li> </ol>

	<p>5. Хэргийн яллагдагчийн төлөөлөгч, өмгөөлөгч, туслахаар оролцож байсан бол;</p> <p>6. Тухайн хэргийн прокурор, шүүхийн ахлах цагдаагийн ажилтны үүргийг гүйцэтгэж байсан бол;</p> <p>7. Тухайн хэргийн үндэслэл болсон шүүх хуралдаанд оролцсон, эсвэл мөрдөн байцаалтад оролцсон бол;</p> <p>8. Гадаадын хуулийн зөвлөхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаар хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хуулийн алба, компанийн хуулийн албанд яллагдагч, хохирогчийн өмгөөлөгч, эсвэл төлөөлөгчөөр ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан өдрөөс хойш хоёр жил өнгөрөөгүй бол;</p> <p>9. Шүүгч эрүүгийн яллагдагч болох хуулийн этгээд, байгууллага, болон байгууллагын удирдах албан тушаалтан, ажилтнаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан өдрөөс хойш хоёр жил өнгөрөөгүй бол.</p> <p><b>18 дугаар зүйл (Шүүгчээс татгалзах хүсэлт гаргах эрх бүхий этгээд)</b></p> <p>(1) Дараах тохиолдолд прокурор, эрүүгийн яллагдагч шүүгчээс татгалзаж болно.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүгч өмнөх зүйлийн дэд зүйлд заасан аль нэг үндэслэл байгаа бол;</li> <li>2. <b>Шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байгаа тохиолдолд;</b></li> </ol> <p>(2) Өмгөөлөгч нь зөвхөн яллагдагч, хохирогчийн хүсэл зоригт харшлаагүй тохиолдолд л шүүгчээс татгалзах хүсэлт гаргаж болно.</p> <p><b>19 дүгээр зүйл (Шүүгчээс татгалзлыг шийдвэрлэх)</b></p> <p>(1) Шүүх бүрэлдэхүүн шүүгчийн татгалзлын талаарх гомдлыг шийдвэрлэхдээ тухайн шүүгчийн харьяалагдах шүүхэд, болон томилсон шүүгч, ганцхан шүүгчид холбогдох татгалзлыг шалгах хэрэг үүсгэнэ.</p> <p>(2) Өргөдөл гаргасан өдрөөс хойш гурав хоногийн дотор татгалзлыг нотлох баримтыг бичгээр бэлтгэнэ.</p> <p><b>20 дугаар зүйл (Татгалзал, хориглолтыг хэрэгсэхгүй болгох)</b></p> <p>(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах зорилготой, эсвэл 19 дүгээр зүйлийн заалтыг илт зөрчсөн нь гомдлыг хүлээн авсан шүүх, шүүгчийн захирамжаар хэрэгсэхгүй болгоно.</p> <p>(2) Өмнөх догол мөрөнд зааснаас бусад тохиолдолд татгалзаж буй шүүгч татгалзал гаргах өргөдлийн талаар бичгээр тайлбар гаргана.</p> <p>(3) Өмнөх догол мөрийн тохиолдолд шүүгчийн татгалзлыг шүүгч үндэслэлтэй гэж хүлээн зөвшөөрсөн бол түүнийг шийдвэр гаргасан гэж үзнэ.</p> <p><b>21 дүгээр зүйл (Татгалзах гомдлыг шийдвэрлэх)</b></p> <p>(1) Шүүгчээс татгалзах гомдлын шийдвэрийг татгалзал гаргаж байгаа шүүгчийн харьяалагдах шүүх бүрэлдэхүүний захирамж гаргаж шийдвэрлэнэ.</p> <p>(2) Өмнөх догол мөрөнд дурдсан шийдвэрт татгалзал гаргасан шүүгч оролцохгүй.</p> <p>(3) Хэрэв татгалзал гаргасан шүүгчийн харьяалагдах шүүх нь шүүх бүрэлдэхүүнгүй бол шууд дээд шатны шүүх шийдвэрлэнэ.</p> <p><b>22 дугаар зүйл (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг татгалзлын улмаас түдгэлзүүлэх үндэслэл)</b></p> <p>(1) Шүүгчээс татгалзах тухай өргөдөл гаргасан тохиолдолд 20 дугаар зүйлийн 1-д зааснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түр түдгэлзүүлнэ: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг яаралтай явуулах тохиолдолд хамаарахгүй.</p> <p><b>23 дугаар зүйл (Татгалзал гаргасан хүсэлтийг хэрэгсэхгүй болгох, нэн даруй гомдол гаргах)</b></p> <p>(1) Шүүгчийн татгалзлыг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийн эсрэг нэн даруй гомдол гаргаж болно.</p> <p>(2) 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэрэгсэхгүй болгосон шийдвэрт нэн даруй гомдол гаргасан нь шүүх хуралдааныг түдгэлзүүлж болохгүй.</p> <p><b>24 дүгээр зүйл (Татгалзах шалтгаан)</b></p> <p>(1) Шүүгч 18 дугаар зүйлд хамаарах шалтгаан байгаа гэж үзвэл уг асуудлыг хэлэлцэхээс татгалзана.</p> <p>(2) Шүүгчээс татгалзах хүсэлтийг шүүгчийн харьяалагддаг шүүхэд бичгээр гаргана.</p> <p>(3) Татгалзах тухай өргөдөлд 21 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх хэрэглэнэ.</p> <p><b>25 дугаар зүйл (Шүүхийн албан тушаалтныг хориглох, татгалзах, татгалзах)</b></p> <p>(1) 17 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд энэ бүлгийн заалтыг IV-ээс VII зэрэглэлийн шүүхийн захиргааны ажилтан, нарийн бичгийн</p>
--	--

	<p>дарга (цаашид "шүүхийн албан тушаалтан" гэх), хэлмэрч зэрэгт дээрх бүлгийн заалтуудыг төсөөтэй хэрэглэнэ.</p> <p>(2) Өмнөх хэсэгт заасны дагуу шүүхийн албан тушаалтан, хэлмэрчийн тэдний харьяалагдах шүүхэд гаргана: 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрийг тухайн шүүхийн шүүгч гаргана.</p>
--	--

БНСУ-ын ИПХ, ЭПХ-ийн зохицуулалт нь эрх зүйн маргааны ялгаатай байдал болон салбар эрх зүйн зарчмын ялгаатай байдлаас шалтгаалан “шүүгчийг татгалзан гаргах үндэслэл” нь ялгаатай бөгөөд нийтлэг татгалзал гаргах үндэслэл нь “үндэслэл бүхий эргэлзээ” байдаг байна.

ИПХ-ийн зохицуулалтын хүрээнд татгалзал гаргахдаа урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд шүүгчээс татгалзах хүсэлт гаргахгүй бол татгалзал гаргах эрхээ алдахаар зохицуулсан нь хязгаарлагдмал зохицуулалт болсон гэж үзэх үндэслэлтэй бай харин ЭПХ-ийн хувьд шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах зорилготой байна гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэвэл уг татгалзлыг хүлээн авдаггүй онцлог зохицуулалт байна.

#### 4. АНУ

АНУ-ын эрх зүйн системийн онцлогоос хамааран “шүүгчийг татгалзан гаргах” гэсэн ойлголтыг “*Disqualification*” гэсэн нэр томъёогоор ойлгож байна. Иймд цаашид “*Disqualification*”-гэх ойлголтыг шүүгчийг татгалзан гаргах хэмээн орчуулав.

"Татгалзах" (эсвэл "эрх хасуулах") гэдэг нь шүүгчийн ашиг сонирхол, эсвэл тусгай мэдлэг, итгэл үнэмшил, үзэл бодолтой хамааралтай шалтгаанаар шүүгч бодит байдлыг бодитойгоор тогтоож хууль зүйн дүгнэлт чадвартай зөрчилдөж байгаа шалтгаанаар шүүгчийг (сайн дураар эсвэл өөр хэлбэрээр) хэргээс татгалзуулах юм.

АНУ-ын ихэнх мужууд Америкийн Хуульчдын Холбоо (АВА)-ны Шүүхийн ёс зүйн загвар дүрмийн мөрдөж иржээ. Харин зарим мужууд Шүүгчийг татгалзан гаргах дүрмийн баталсан байдаг, тухайлбал **шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээтэй**, өмнө нь энэ асуудалд өмгөөлөгчөөр ажиллаж байсан, тухайн асуудалд эдийн засгийн ашиг сонирхолтой, ураг төрлийн гурав дахь зэрэгт хамаарах төрөл садан, хэргийн оролцогч буюу өмгөөлөгч нь маргаантай нотлох баримтын талаар хувийн мэдлэгтэй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад харилцаа холбоотой болсон зэргийг шүүгчийг татгалзан гаргах үндэслэлд тооцдог байна.

#### АНУ-ын Хуульчдын Холбооны Шүүхийн ёс зүйн загвар дүрэм<sup>35</sup>

##### Дүрэм 2.11. Татгалзал гаргах үндэслэл

(А) **Шүүгчийн шударга байдлын талаар үндэслэл бүхий эргэлзээ** байвал аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч өөрөө татгалзана, үүнд дараах нөхцөл байдал орно, гэхдээ дараах тохиолдлоор хязгаарлагдахгүй.

1. Шүүгч хэргийн оролцогч тал эсвэл түүний өмгөөлөгчийн талаар хувийн өрөөсгөл ойлголт (personal bias), урьдчилан тааварласан үзэлтэй байх эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаантай байгаа баримтуудын талаар хувийн мэдлэгтэй\*.
2. Шүүгчийн хувийн мэдлэг\* шүүгчийн эхнэр, нөхөр, гэр бүлийн хамтрагч\*, эсвэл тэдгээрийн аль нэгтэй нь гуравдагч зэрэглэлийн харилцааны садны хүн\*, эсвэл ийм хүний эхнэр, нөхөр, гэрийн хамтрагч гэдэг нь:

<sup>35</sup> Model Code of Judicial Conduct - American Bar Association, [https://www.americanbar.org/groups/professional\\_responsibility/publications/model\\_code\\_of\\_judicial\\_conduct/model\\_code\\_of\\_judicial\\_conduct\\_canon\\_2/rule2\\_11disqualification/](https://www.americanbar.org/groups/professional_responsibility/publications/model_code_of_judicial_conduct/model_code_of_judicial_conduct_canon_2/rule2_11disqualification/) (Сүүлд үзсэн: 2022.11.22).

- (а) хэргийн оролцогч, эсвэл албан хаагч, захирал, хамтрагч, удирдах зөвлөлийн гишүүн, итгэмжлэгдсэн төлөөлөгч;
- (б) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч;
- (в) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ихээхэн нөлөөлж болохуйц сонирхол бүхий этгээд;
- (г) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гэрч байх магадлалтай этгээд
- (3) Шүүгч нь итгэмжлэгдсэн этгээдийг мэддэг байх\* эсвэл шүүгчийн эхнэр, нөхөр, гэр бүлийн хамтрагч, эцэг эх, хүүхэд, шүүгчийн гэр бүлд оршин суудаг бусад гишүүн\* маргаантай байгаа эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талтай эдийн засгийн ашиг сонирхолтой\* байх. Шүүгч хэргийн оролцогч аль нэг талын өмгөөлөгч, эсвэл аль нэг талын өмгөөлөгчийн өмгөөллийн фирм урьд өмнө нь гаргасан хүсэлтийн хүрээнд мэддэг, түүний оруулсан хувь нэмрийг мэддэг байх
- (5) Шүүгч, шүүгчид нэр дэвшигч\* байхдаа шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэр, дүгнэлтээс бусад тохиолдолд шүүн таслах ажиллагаа, маргааны явцад тодорхой үр дүнд хүрэх, шийдвэр гаргахад шүүгч үүрэг хүлээсэн буюу үүрэг хүлээсэн мэт харагдахуйц олон нийтэд мэдэгдэл хийсэн.
- (6) Шүүгч:
  - (а) маргаантай асуудалд өмгөөлөгчөөр ажилласан, эсвэл хэргийн өмгөөлөгчтэй хамтран ажилладаг байсан;
  - (б) төрийн албанд ажиллаж байсан, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн албан тушаалтнаар биечлэн болон өмгөөлөгчөөр нь оролцсон, эсвэл маргаантай байгаа тухайн асуудлын ач холбогдлын талаар санал бодлоо олон нийтэд илэрхийлсэн;
  - (в) уг хэргийн талаар гэрч байсан;
  - (г) өмнө нь өөр шүүхэд уг маргааны даргалагч шүүгч байсан.

АНУ-ын шүүгчийг татгалзан гаргах тухай зохицуулалт нь тус улсын Үндсэн хуулийн Арван дөрөв дэх нэмэлт, өөрчлөлтийн заалт болох Зохистой журам (due process) болон муж тус бүрээр үндсэн хуулийн заалтууд, хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн дүрэм, шүүхийн жишиг уламжлалаар зохицуулагддаг ба тухайн хэргийн талаар хувийн өрөөсгөл ойлголт (personal bias) байгаа тохиолдолд татгалзал гаргаж болдог байна.

## 5. БНЛУ

<p><b>ИПХ-ийн зохицуулалт<sup>36</sup></b></p>	<p><b>ИПХ-ийн 18 дугаар хэсэгт Шүүгч урьд нь хянан шийдвэрлэсэн маргаандаа дахин оролцохгүй байх талаар зохицуулсан.</b></p> <p>18.1 дэх хэсэгт Анхан шатны шүүхээр хэргийг шийдвэрлэхэд оролцсон шүүгч ижил хэргийн давах болон хяналтын шатны хянан шийдвэрлэх ажиллагаа болон анхан шатаар тухайн хэрэг дахин хянагдахад оролцохгүй, хэрэв хэргийг хэрэгсэхгүй болгох эсхүл хэргийг хянан хэлэлцүүлэхгүйгээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гаргахад шүүгч оролцсон бол оролцохгүй.</p> <p>18.2 Хэргийг давж заалдах эсхүл хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч ижил хэргийг анхан эсхүл давж заалдах шатны шүүхээр хянан хэлэлцүүлэхэд оролцохгүй.</p> <p><b>19 дүгээр хэсэг. Шүүгчийг татгалзах</b></p> <p>19.1 Шүүгч дараах хэргийг хянан хэлэлцэхэд оролцох эрхгүй:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Өмнөх шатны шүүх хуралд нарийн бичгийн дарга, орчуулагч, шинжээч, гэрч, хэргийн оролцогчоор оролцсон;</li> <li>2. Хэргийн оролцогчдын хэн нэгэнтэй нь гуравдугаар зэргийн хамаатан садны харилцаатай эсхүл хоёрдугаар зэргийн төрөл садны харилцаатай;</li> <li>3. Хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүний гишүүн шүүгчийн хэн нэгэнтэй нь гуравдугаар зэргийн хамаатан садны харилцаатай эсхүл хоёрдугаар зэргийн төрөл садны харилцаатай;</li> </ol>
--	--

<sup>36</sup> <https://likumi.lv/ta/en/en/id/50500-civil-procedure-law> (Сүүлд үзсэн: 2022.11.21).

	<p><b>4. Хэргийн үр дүнд шууд болон шууд бус хувийн ашиг сонирхолтой эсхүл бусад нөхцөл байдлууд түүнийг үнэн зөвөөр хэргийг шийдвэрлэх тухайд үндэслэл бүхий эргэлзээ үүсгэсэн.</b></p> <p>19.2 Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэг эсхүл 18 дугаар хэсэгт заасан нөхцөл байдлууд үүсвэл шүүгч хэргийн шүүх хуралдаанаас өмнө өөрөө татгалзан гарна.</p> <p>19.3 Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал шүүх хуралдааны үед тогтоогдвол шүүгч шүүх хуралдааны үед өөрийн санаачилгаар татгалзлын шалтгаанаа тайлбарлан татгалзан гарна. Энэ тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хойшлуулна.</p> <p>19.4 Хэрэв шүүгч өөрийн санаачилгаар татгалзан гараагүй бол хэргийн оролцогчдын хэн нэг нь энэ хэсэгт заасан үндэслэлээр шүүгч тус бүрийг татгалзах болсон шалтгаанаа тайлбарлан <b>шүүгч эсхүл хэд хэдэн шүүгчийг хамтад нь татгалзах хүсэлт гаргаж болно.</b></p> <p><b>20 дугаар хэсэг. Татгалзах хүсэлт</b></p> <p>20.1 Хэргийн оролцогчид бичгээр эсхүл амаар шүүгчээс татгалзах хүсэлтийг гаргаж болно. Уг хүсэлтийн талаар шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглэл хийнэ.</p> <p>20.2 Татгалзах хүсэлтийг хэргийн үндэслэлийг хянан хэлэлцэж эхлэхээс өмнө гаргана. Татгалзлыг хэрэв үндэслэл нь шүүх хуралдааны явцад тодорхой болсон бол хүсэлтийг дараа нь гаргаж болно.</p> <p><b>21 дугаар хэсэг. Татгалзах хүсэлтийг хянах үйл явц</b></p> <p>21.1 Шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хэргийн бусад оролцогчдын болон татгалзаж буй шүүгчийн саналыг сонсоно.</p> <p>21.2 Татгалзал шүүх хуралдааны дунд гарсан тохиолдолд шүүх зөвлөлдөх журмаар шийдвэрлэнэ.</p> <p>21.3 Шүүгч дангаар хэргийг шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүгчийг татгалзах асуудлыг дангаар шийдвэрлэж байгаа шүүгч шийднэ.</p> <p>21.4 <b>Бүрэлдэхүүнээр хэргийг шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүгчийг татгалзах хүсэлтийг дараах журмаар шийдвэрлэнэ:</b></p> <p>1. Нэг шүүгчийг татгалзахаар хүсэлт гаргасан тохиолдолд бүрэлдэхүүний бусад шүүгчид шийдвэрлэнэ. Хэрэв шүүгчдийн санал тэнцсэн бол тухайн шүүгчийг татгалзсанд тооцно.</p> <p>2. Хэрэв нэгээс олон шүүгчдийг татгалзахаар хүсэлт гаргасан тохиолдолд тухайн шүүх бүрэлдэхүүн бүрэн бүрэлдэхүүнээрээ олонхын саналаар шийдвэрлэнэ.</p> <p><b>22 дугаар хэсэг. Татгалзах хүсэлтийг хангасны үр дагавар</b></p> <p>22.1 <b>Хэрэв шүүгч эсхүл хэд хэдэн шүүгчдийг татгалзан гаргасан бол хэргийг тухайн шүүхийн өөр шүүх бүрэлдэхүүнээр хэлэлцэнэ.</b></p> <p>22.2 <b>Хэрэв тухайн шүүхэд өөр шүүх бүрэлдэхүүн бүрэлдэхгүй бол хэргийг дүүргийн (хотын) өөр шүүхэд эсхүл мужийн өөр шүүхэд шилжүүлнэ.</b></p> <p>Мөн хуулийн 32 дугаар хэсгийн 2.2-т зааснаар <b>“нэг эсхүл хэд хэдэн шүүгчийг татгалзан гаргасан тохиолдолд тухайн шүүх шүүгчийг орлуулах боломжгүй бол хэргийг өөр шүүхэд шилжүүлж болно”.</b></p>
<p><b>ЭПХ-ийн зохицуулалт<sup>37</sup></b></p>	<p><b>ЭПХ-ийн 50 дугаар хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэй бол оролцуулахгүй байх талаар зохицуулсан.</b></p> <p>50.1 Албан тушаалтан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /ЭХХША/ явуулснаар ашиг сонирхлын зөрчилд орохоор бол ЭХХША явуулахыг зөвшөөрөхгүй. Ашиг сонирхлын зөрчилд орох гэдэгт тухайн хүний хувийн ашиг сонирхол ЭХХША-ны зорилготой шууд болон шууд бусаар давцахгүй байх</p>

<sup>37</sup> <https://likumi.lv/ta/en/en/id/107820-criminal-procedure-law>, (Сүүлд үзсэн: 2022.11.21).

эсхүл ЭХХША-нд оролцож буй этгээдэд тийм ашиг сонирхлыг зөвшөөрөх үндэслэл бүхий нөхцөл байдал байгаа гэдгийг ойлгоно.

50.3 Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд нь ашиг сонирхлын зөрчил илэрсэн үеэс аль болох хурдан ЭХХША явуулахаас татгалзана.

50.4 ЭХХША явуулж буй этгээд нь ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийн ЭХХША-нд оролцохгүй байх үүрэгтэй тул холбогдох хүрээнд татгалзан гарна.

**51 дүгээр хэсэг. Ашиг сонирхлын зөрчлийг нотлох нөхцөлүүд**

Дараах тохиолдолд өөр нөхцөл байдлуудыг тогтоох шаардлагагүйгээр ашиг сонирхлын нөхцөл гэж тооцно:

1. Гуравдугаар зэргийн хамаатан садны харилцаатай эсхүл хоёрдугаар зэргийн төрөл садны харилцаатай эсхүл шүүгдэгч, хохирогч болон тэдгээрийн төлөөлөгчтэй гэрлэсэн;
2. Эхнэр/нөхөр, хүүхэд, эцэг эх шүүгдэгч, хохирогч болон тэдний төлөөлөгчдөөс орлого хүлээн авсан эсхүл хүлээн авдаг;
3. Шүүгдэгч, хохирогч болон тэдний төлөөлөгчтэй гэр бүлийн харилцаатай;
4. Шүүгдэгч, хохирогч болон тэдний төлөөлөгчтэй ашиг сонирхлын илт зөрчилтэй;
5. Тухайн хэргийн гэрч, хохирогч эсхүл тэдний төлөөлөгч эсхүл тухайн хэргийн шүүгдэгч, шүүгдэгч байсан эсхүл хохирогчийн төлөөлөгч байсан бол ашиг сонирхлын зөрчилтэй гэж тооцно.

**52 дугаар хэсэг. ЭХХША-нд оролцсон хувь хүмүүсийн ашиг сонирхлын зөрчил**

52.1 Хэргийг хянан шалгаж буй шүүгч, хэргийг чиглүүлэн явуулж буй этгээд, хяналтын прокурор нь хоорондоо гэрлэлтээр холбогдсон, гэр бүлийн холбоотой, нэгдүгээр зэргийн садан төрлийн холбоотой тохиолдолд нэг хэрэгт хамт оролцохгүй.

52.4 Шүүгч дараах тохиолдолд хэргийг хянан шийдвэрлэхэд оролцохгүй:

1. Эрүүгийн хэргийг урьдчилан шийдвэрлэхэд оролцсон эсхүл анхан болон давж заалдах шатанд аль ч статусаар оролцсон;
2. Гуравдугаар зэргийн хамаатан садны харилцаатай эсхүл хоёрдугаар зэргийн төрөл садны харилцаатай эсхүл хэрэгт оролцож буй өөр шүүгч, улсын яллагч, хэргийг шүүхэд шилжүүлсэн прокурортой гэрлэсэн эсхүл хэрэгт оролцож буй өөр шүүгч, улсын яллагч, хэргийг шүүхэд шилжүүлсэн прокурортой гэр бүлийн холбоотой бол хэргийг хянан шийдвэрлэхэд оролцохгүй.

**54 дүгээр хэсэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах**

54.1 Ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг ЭХХША-наас татгалзан гаргах хүсэлтийг дараах этгээдэд гаргана:

- Хяналтын шүүгч – ерөнхий шүүгчид;
- Шүүх хуралдааныг эхлүүлэх хүртэл эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр шилжүүлсний дараа шүүгч – ерөнхий шүүгчид;
- Эрүүгийн хэргийг хэлэлцэж буй шүүгч – шүүх бүрэлдэхүүнд;
- Ерөнхий шүүгч – Дээд шатны шүүхийн ерөнхий шүүгчид.

**55 дугаар хэсэг. Татгалзах хүсэлт гаргах**

1. Шүүгдэгч, хохирогч эсхүл ЭХХША явуулах эрх бүхий этгээд хэрэв тухайн этгээд ЭХХША явуулахыг хориглосон нөхцөл байвал 54 дүгээр хэсэгт заасан этгээдэд татгалзах хүсэлтийг гаргана. **54.1-т заасан этгээд татгалзлыг шийдвэрлэх эрхтэй.** Хэрэв прокурорыг татгалзах хүсэлт шүүх хуралдааны явцад гарвал шүүх бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв хяналтын шүүгчийг татгалзах хүсэлтийг шүүх хуралдааны явцад гаргавал хяналтын шүүгч уг асуудлыг шийдвэрлэнэ.

2. Эрүүгийн хэрэг урьдчилсан хэлэлцүүлэг болон хэргийг шалгах явцад болон шүүх хуралдаан эхлэх хүртэл татгалзал гаргаж байгаа бол бичгээр гаргана.

	<p>Харин шүүх хуралдааны явцад татгалзлыг амаар гаргаж шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглэнэ.</p> <p>3. <b>Татгалзлыг ижил үндэслэлээр нэгээс олон удаа гаргахгүй.</b></p> <p>4. <b>Татгалзал нь тухайн этгээдийн тодорхой ЭХХША явуулсан үйлдлийг нь үндэслэж болохгүй.</b> Тус үйлдэлд энэ хуульд заасан журмаар давж заалдаж болно.</p> <p><b>56 дугаар хэсэг. Татгалзан гаргах шийдвэр гаргах</b></p> <p>56.1 Татгалзан гаргах хүсэлтийг хойшлуулахгүйгээр шалгана. Татгалзах үндэслэл тогтоогдсон эсхүл татгалзан гаргах үндэслэлгүй байвал шийдвэр гарна.</p> <p>56.2 Татгалзах хүсэлт гаргасан этгээдээс ямар ч тохиолдолд тайлбар авна.</p> <p>56.3 Онцгой тохиолдолд шийдвэр гарах хүртэл гүйцэтгэлийн үүргээс чөлөөлөгдөнө.</p> <p><b>57 дугаар хэсэг. Татгалзсан шийдвэрийг давж заалдах</b></p> <p>1. Хуульд заасан нөхцөлд татгалзан гаргах шийдвэрийг эсэргүүцэн 10 хоногийн дотор гомдол гаргаж болно.</p> <p><b>58 дугаар хэсэг. Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж чадаагүйн үр дагавар</b></p> <p>1. Тухайн этгээдийг ЭХХША-нд оролцуулахгүй байхуйц ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж чадаагүй этгээд хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.</p> <p>2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл нь холбогдох этгээдийн гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, олж авсан нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх эсэхэд эргэлзэх үндэслэл болно.</p>
--	---

БНЛУ-ын ИПХ, ЭПХ-ийн аль алинд нь “шүүгчийг татгалзан гарах үндэслэл”-ийг хуульчлан зохицуулжээ. Тухайлбал, өмнөх шатны шүүхээр тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон, хэргийн оролцогчидтой төрөл садны холбоотой, тухайн хэрэгт хэргийн оролцогчоор оролцож байсан г.м. Түүнчлэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч өөрийн санаачилгаараа татгалзан гарах болон хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг гаргах боломжтой.

БНЛУ-ын ИПХ, ЭПХ-ийн зохицуулалтын ялгаа нь иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч тухайн хэргийн үр дүнд шууд болон шууд бусаар хувийн ашиг сонирхолтой эсхүл түүнийг хэргийг бодитоор шийдвэрлэх эсэхэд үндэслэл бүхий эргэлзээг үүсгэсэн бусад нөхцөл байдал байвал татгалзан гаргах үндэслэл болдог бол эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад шүүгч ашиг сонирхлын зөрчилтэй бол татгалзан гаргах үндэслэл болно.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад нэг болон хэд хэдэн шүүгчээс зэрэг татгалзах боломжтой. Энэ тохиолдолд тухайн хэргийг шийдвэрлэх боломжтой ижил түвшний өөр шүүхэд шилжүүлэхээр зохицуулсан нь ихээхэн онцлог зохицуулалт байна гэж үзлээ.

## 6. ОХУ

ОХУ-ын эрүүгийн, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “шүүгчийг татгалзан гаргах”-тай холбогдох эрх зүйн зохицуулалтыг судалсныг доорх байдлаар харуулав:

ИПХ-ийн зохицуулалт	<p><b><u>16 дугаар зүйл. Шүүгчийг татгалзан гаргах үндэслэл</u></b><sup>38</sup></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Анхан шатны шүүх, түүнчлэн шүүгч хэргийг хянан шийдвэрлэж болохгүй, хэрвээ шүүгч:       <ol style="list-style-type: none"> <li>1) Энэ хэргийг өмнө нь хэлэлцэх явцад прокурор, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, итгэмжлэгдсэн төлөөлөгч, гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагчаар оролцсон;           <ol style="list-style-type: none"> <li>1.1. Энэ хэрэгт шүүхийн эвлэрүүлэн зуучлагчаар оролцож байсан;</li> </ol> </li> <li>2) Энэ хэргийн оролцогч этгээдүүдийн аль нэг эсхүл тэдний төлөөлөгчийн ойрын хамаатан эсхүл төрөл садан</li> <li>3) <b>Хэргийн үйл явцыг өөрийн биеэр, шууд болон шууд бус байдлаар сонирхож байгаа, эсхүл шүүгчийн бодитой, шударга байдалд эргэлзэж буй бусад нөхцөл байдал байвал;</b></li> </ol> </li> <li>2. Хэргийг хянан хэлэлцэж буй шүүхийн бүрэлдэхүүнд өөр хоорондоо холбоотой хүмүүсийг оролцуулж болохгүй.</li> <li>3. Иргэний хэргийн процессын бус шүүгчид ирсэн хүсэлтийн тухай мэдээллийг шүүгчийг татгалзан гаргах үндэслэл гэж үзэх боломжгүй.</li> </ol> <p><b><u>19 дүгээр зүйл. Өөрөө татгалзан гарах болон татгалзан гаргах хүсэлт</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Энэ хуулийн 16-аас 18 дугаар зүйлүүдэд заасан татгалзан гарах үндэслэл байвал анхан шатны шүүх, түүнчлэн шүүгч, прокурор, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, мэргэжилтэн, хэлмэрч өөрөө татгалзан гарч байгаагаа мэдэгдэх үүрэгтэй. Үүнтэй адил үндэслэлээр хэргийн оролцогчид татгалзлыг эсэргүүцэж, шүүхийн санаачилгаар хэлэлцэж болно.</li> <li>2. Өөрөө татгалзан гарах хүсэлт нь үндэслэлтэй байх ёстой бөгөөд хэргийг хянан хэлэлцэж эхлэхээс өмнө энэ талаар мэдэгдэнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсний дараа шүүгч хэргийг хянан шийдвэрлэхээс өөрөө татгалзах буюу татгалзан гарах үндэслэл нь тодорхой болсноор өөрөө татгалзан гарах, татгалзлаа илэрхийлж шүүхэд мэдэгдэл гаргасан бол, энэхүү мэдэгдлийг хүлээж авна.</li> <li>3. Шүүгчийн өөрөө татгалзан гарах хүсэлтийг шийдвэрлэх журам, түүнийг хангаснаар гарах үр дагаврыг энэ хуулийн 20 болон 21 дүгээр зүйлд заасан журмын дагуу тогтооно.</li> <li>4. <b>Татгалзан гарах тухай хүсэлтийг хангахаас татгалзсан тохиолдолд нэг этгээд, ижил үндэслэлээр дахин гомдол гаргах эрхгүй.</b></li> </ol> <p><b><u>20 дугаар зүйл. Татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх журам</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Татгалзан гаргах тохиолдолд шүүх хэргийн оролцогч, түүнчлэн хүсвэл татгалзан гарч байгаа этгээдийн саналыг сонсоно.</li> <li>2. Хэргийг дангаар хянан шийдвэрлэж буй шүүгчийг татгалзан гаргасан буюу шүүгч өөрөө татгалзан гарсан асуудлыг зөвлөлдөх тасалгаанд авч хэлэлцэлгүйгээр протоколын хөтлөн шийдвэрлэх болно. Шүүгчид хэргийг хамтаар хэлэлцэх үед хүсэлтийг шүүх хуралдааны танхимд шүүх бүрэлдэхүүн захирамж гарган шийдвэрлэнэ. Шүүгчийн татгалзлыг тухайн шүүгчийн эзгүйд шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэнэ. Хэд хэдэн шүүгчид, эсхүл шүүхийн нийт бүрэлдэхүүнд гаргасан маргааныг тухайн шүүх бүхэлд нь олонхын саналаар шийдвэрлэнэ. Хүсэлт гаргахыг дэмжсэн болон татгалзсан саналын тоо тэнцүү байвал шүүгчийг татгалзан гаргасанд тооцно. Прокурор, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга, шинжээч, мэргэжилтэн, хэлмэрчийг татгалзан гаргах тухай асуудлыг тухайн хэрэг хянан хэлэлцэж байгаа шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.</li> </ol> <p><b><u>21 дүгээр зүйл. Татгалзан гаргах үндэслэлийг хангасны үр дагавар</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. <b>Тухайн хэргийг хянан хэлэлцэж байгаа анхан шатны шүүгчээс татгалзсан тохиолдолд дүүргийн шүүх тухайн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй анхан шатны шүүхийн өөр шүүгчид шилжүүлнэ, эсхүл шилжүүлэх боломжгүй тохиолдолд дээд шатны шүүхээс өөр дүүргийн анхан шатны шүүгчид шилжүүлнэ.</b></li> <li>2. <b>Хэргийг дүүргийн шүүх хянан хэлэлцэх явцад шүүгч татгалзсан эсхүл шүүхийн нийт бүрэлдэхүүн татгалзсан тохиолдолд тухайн шүүх бүрэлдэхүүнд өөр шүүгч, эсхүл шүүхийн өөр бүрэлдэхүүн хянан</b></li> </ol>
------------------------	--

	<p><b>хэлэлцэнэ, эсхүл шүүхэд шилжүүлнэ. Хэргийг хянан хэлэлцэж буй дүүргийн шүүхэд шүүгчийг солих боломжгүй тохиолдолд дээд шатны шүүх өөр дүүргийн шүүхээр хянан шийдвэрлүүлнэ.</b></p> <p>3. Бүгд Найрамдах Улсын Дээд шүүх, Бүс нутгийн шүүх, Холбооны ач холбогдол бүхий хотын шүүх, Автономит мужийн шүүх, Автономит дүүргийн шүүх, Ерөнхий харьяаллын давж заалдах шатны шүүх, Ерөнхий харьяаллын кассын шүүх, ОХУ-ын Дээд шүүхээр хэргийг хянан хэлэлцэх явцад шүүгчээс татгалзах, шүүх бүрэлдэхүүнээс бүхэлд нь татгалзах тохиолдолд тухайн хэргийг өөр шүүгч эсхүл өөр шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүхээр хянан хэлэлцэнэ.</p> <p>4. Давж заалдах хүсэлтийг хангасны дараа буюу бусад шалтгаанаар энэ хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн бүрэлдэхүүнийг шинээр бүрдүүлэх боломжгүй бол энэ хуулийн 33 дугаар зүйлийн хоёр дахь хэсгийн 4 дэх хэсэгт заасан журмаар хэргийг өөр шүүхэд шилжүүлнэ гэж тус тус хуульчилсан байна.</p>
<p><b>ЭПХ-ийн зохицуулалт</b></p>	<p><b><i>Бүлэг 9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй тохиолдол</i><sup>39</sup></b></p> <p><b><u>61 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож боломжгүй нөхцөл байдал</u></b></p> <p>1. Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэлтийн газрын дарга, хэрэг бүртгэлтийн хэлтсийн дарга, байцаагч нь дараах тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Хэргийн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, гэрч;</li> <li>2) Тангарагтны шүүгч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, гэрч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, өмгөөлөгч, сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн төлөөлөгч, мөн шүүгчээр оролцсон - энэ эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророор оролцсон;</li> <li>3) Энэ эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын аль нэгнийх нь ойрын хамаатан, төрөл садан.</li> </ol> <p>2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдүүд эрүүгийн хэргийн үр дүнг биечлэн болон шууд бусаар сонирхож байна гэж үзэх үндэслэл бүхий бусад нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг хориглоно.</p> <p>3. Эрүүгийн хэргийн шүүгчийн хүлээн авсан байцаан шийтгэх ажиллагааны бус давж заалдах гомдлын талаар мэдээлэл байгаа нь шүүгчээс татгалзах үндэслэл гэж үзэхгүй.</p> <p><b><u>63 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчийг давтан оролцуулахыг зөвшөөрөхгүй байх</u></b></p> <p>1. Эрүүгийн хэргийг анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэхэд шүүгч тус эрүүгийн хэргийг нэгдүгээр давж заалдах шатны эсвэл хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүйтэй адил түүний оролцоотойгоор гаргасан шийтгэх тогтоол, түүнчлэн тодорхойлолт (магадлал), эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тогтоолыг хүчингүй болгосны дараа тухайн хэргийг нэгдүгээр давж заалдах шатны шүүхэд шинээр хянан хэлэлцэхэд оролцож болохгүй.</p> <p>2. Эрүүгийн хэргийг нэгдүгээр давж заалдах шатны шүүхэд хянан хэлэлцэхэд оролцсон шүүгч тухайн эрүүгийн хэргийг анхан шатны шүүхийн эсвэл хяналтын журмаар хянан хэлэлцэхэд оролцож болохгүйтэй адил түүний оролцоотойгоор гаргасан шийтгэх тогтоол, түүнчлэн тодорхойлолт (магадлал), эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тогтоолыг хүчингүй болгосны дараа тухайн хэргийг нэгдүгээр давж заалдах шатны шүүхэд шинээр хянан хэлэлцэхэд оролцож болохгүй.</p> <p>3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналтын журмаар оролцсон шүүгч тухайн эрүүгийн хэргийг анхан болон давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.</p> <p><b><u>64 дүгээр зүйл. Шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргах</u></b></p>

<sup>39</sup><http://www.consultant.ru/cons/cgi/online.cgi?req=doc&base=LAW&n=428402&dst=0&edition=etD&rnd=AZeiHQ#1ztdQNT0Ce2N6iYm>, (Сүүлд үзсэн: 2022.11.18).

	<p>1. Энэ хуулийн 61, 63 дугаар зүйлд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үеэр хэргийн оролцогчид шүүгчээс татгалзаж болно.</p> <p>2. Шүүгчээс татгалзсан өргөдлийг шүүхийн мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэхээс өмнө, эрүүгийн хэргийг шүүх тангарагтны бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж байгаа тохиолдолд тангарагтны бүрэлдэхүүн байгуулахаас өмнө мэдэгдэнэ. Шүүхийн мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэхээс өмнө, эрүүгийн хэргийг шүүх тангарагтны бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж байгаа тохиолдолд тангарагтны бүрэлдэхүүн байгуулахаас өмнө мэдэгдэнэ.</p> <p><b><u>65 дугаар зүйл. Шүүгчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг хэлэлцэх журам</u></b></p> <p>1. Шүүгчийг татгалзан гаргах гомдлыг шүүх хуралдааны танхимд магадлал, тогтоол гарган шийдвэрлэнэ.</p> <p>2. Эрүүгийн хэргийг шүүх хамтаар авч хэлэлцэж байсан бол шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шүүгчийн эзгүйд бусад шүүгчид шийдвэрлэнэ. Татгалзан гарах хүсэлт авсан шүүгч бусад шүүгчдийг зөвлөлдөх танхимаас гарахаас нь өмнө өөрийн эсэргүүцлээ олон нийтэд илэрхийлэн мэдэгдэх эрхтэй.</p> <p>3. Хэд хэдэн шүүгчид, эсхүл шүүхийн нийт бүрэлдэхүүнд гаргасан татгалзлыг тухайн шүүх нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.</p> <p>4. Эрүүгийн хэргийг дангаар хянан хэлэлцэж байгаа шүүгчийг татгалзан гаргах, эсхүл таслан сэргийлэх арга хэмжээ авах, мөрдөн байцаалт явуулах тухай хүсэлт, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болгосон шийдвэрт давж заалдах гомдол гаргахыг мөн адил зөвшөөрнө.</p> <p>5. Шүүгч, хэд хэдэн шүүгч, эсхүл нийт шүүгчдийн бүрэлдэхүүнийг татгалзан гаргах тухай хүсэлтийг хангасан бол эрүүгийн хэрэг, хүсэлт, гомдлыг энэ хуульд заасан журмын дагуу өөр шүүгч, шүүхийн бусад бүрэлдэхүүнд тус тус шилжүүлнэ.</p> <p>6. Шүүгчийг татгалзан гаргахтай зэрэгцэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч бусад этгээдийг татгалзан гаргасан бол шүүгчийн татгалзан гарах асуудлыг түрүүнд нь шийдвэрлэнэ.</p>
--	--

ОХУ-ын ИХХША-ны журамд /УГС буюу Устав гражданского судопроизводства/ заасан шүүгчээс татгалзах татгалзлын цаг хугацааны хязгаарлалтын талаар Е.А.Нефедьев<sup>40</sup> шүүмжлэлтэй хандсан байдаг бөгөөд энэхүү шүүмжлэлд тухайн шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байж болох, түүнд хамааралтайгаар шүүгчийн чадварыг тодорхойлон авч үзсэн.

*Ийнхүү татгалзан гаргах үндэслэлээс нь хамааран Е.А.Нефедиев шүүгчдийг дараах байдлаар хуваасан байна. Үүнд:*

- 1) Түйлын чадваргүй шүүгч /ерөнхийдөө чадваргүй/ - Өөрөөр хэлбэл, шүүгчийн албан тушаал, шүүхийн бүрэлдэхүүнд орох эрх байхгүй буюу шүүгчийн ажлыг гүйцэтгэж чадахгүй эсхүл тухайн ажлын байранд байх эрхгүй шүүгчийг ойлгоно. Жишээ нь: хамаатан садны оролцоотойгоор тухайн ажлын албанд орж ирсэн хүн хамаарна.
- 2) Харьцангуй ажиллах чадваргүй шүүгч - энэ төрлийн шүүгч тухайн албан тушаалд байх нь хуулийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн. Үүнд: шүүгч болон шүүгдэгчийн хооронд маргаан үүссэн; гэр бүлийн харилцан хамаарал /хамаатан садан/, эсхүл эд хөрөнгийн холбоотой асуудалд холбогдсон шүүгч хамаарна.
- 3) Сэжиг бүхий шүүгч /эргэлзээтэй/ - Өөрөөр хэлбэл, хэрэгт оролцох эрхтэй эсэхийг нь хуульд шууд зохицуулж өгөөгүй сэжигтэй шүүгчдийг ойлгоно. Улмаар эдгээр шүүгчдийг ийнхүү сэжиглэж байгаа /эргэлзээ/ нь хэргийн оролцогчдын үзэл санаанаас үүдэлтэй бөгөөд үүнтэй холбоотойгоор шүүгчийн үнэмлэхүй чадварыг албан ажлаа гардан авах үед нь шалгаж, түүнд тавигдах шаардлагыг шүүхийн журмаар тодорхойлсон байх (шүүхийн журмыг тогтоох), мөн өөрийн хамаатан саднаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахгүйн тулд шүүх бүрэлдэхүүний даргалагч тус бүрэлдэхүүнийг

<sup>40</sup> Евгений Алексеевич Нефедиев (1851-1910) - Хуульч, Москвагийн их сургуулийн профессор.  
<https://doi.org/10.37399/2686-9241.2021.1.113-127>

байгуулах явцад түүний уг чадварыг шалгах зэргээр уг нөхцөл байдлыг тодорхой болгоно.

Иймд, дээр дурдсан шүүгчийн харьцангуй чадварыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд чангатган зохицуулсан (ИХХША-ны журмын 667 дугаар зүйл). Шүүгчийн үнэмлэхүй болон харьцангуй чадвар нь процессын үйл явцаар илрэн гарах таамаглал бөгөөд үнэхээр чадваргүй, харьцангуй чадваргүй шүүгчийг төрийн болон нийтийн эрх ашиг сонирхлоор татгалзан гаргадаг.

Харин сэжиг бүхий шүүгчийн хувьд нөхцөл байдал арай өөр: Тухайн шүүгчид эргэлзэх үндэслэлийг хуульд тусгайлан зааж өгөөгүй боловч ерөнхий байдлаар авч үзсэн байдаг. *“Хэргийн үйл явцын үр дүнг сонирхсон”, “шүүгчийн шударга байдалд эргэлзсэн бусад нөхцөл байдал” гэх мэт.* Эдгээр эргэлзээтэй байдал нь шүүх хуралдааны оролцогчдод үүсэж болзошгүй нөхцөл байдал учир энэ талаар мэдүүлж, шүүгчийг татгалзан гаргадаг. Иймд сэжиг бүхий буюу түүний ур чадварт эргэлзэж болох шүүгчээс татгалзах асуудлыг хэргийн оролцогчдын хүсэлт, тэдгээрийн ашиг сонирхолд үндэслэн шийдвэрлэдэг<sup>41</sup> хэмээн тэмдэглэсэн байна.

Шүүгч өөрөө татгалзан гаргах хүсэлт гаргаж байгаа тохиолдол нь өөрөө өөрийгөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргаж байгаа хэлбэр биш бөгөөд энэ нь шүүгч өөрөө өөрийгөө татгалзан гаргах зөвшөөрөл авч буйн илрэл гэж ойлгох нь зүйтэй<sup>42</sup> ба эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгчээс татгалзах хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол уг нөхцөл байдлыг давж заалдах гомдолд дурдаж болно гэжээ. (Москва хотын шүүхийн 2021 оны 6-р сарын 22-ны өдрийн 10-11620/2021 тоот давж заалдах шатны шийдвэр)<sup>43</sup>.

**Улсын Дээд шүүхийн нийт хуралдааны 2007 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 27 дугаар тогтоол<sup>44</sup>**

***“Ерөнхий шүүхийн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх тухай шүүгчийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэрээс татгалзсан хэргийг шүүх хянан хэлэлцэх практикийн тухай” Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол.***

*Энэхүү тогтоолын 10 дугаар зүйлд зааснаар:*

***“Шүүгч ноёрхуу, биеэ тоосон зан чанартай байж болохгүй ба тэрээр шүүх хуралдааны үеэр эелдэг, тайван өнгө аястай, байж шүүх хуралдаанд оролцогчид болон шүүх хуралдаанд оролцож буй бусад хүмүүст хүндэтгэлтэй, ойлгож, тэвчээртэй хандах ёстой. Шүүхийн танхимд буюу шүүх хуралдаанд иргэдийн эрээ цээргүй авирлаж байгаа нь шүүгчийг иргэдэд эелдэг, бодитой, шударга хандах үүргээс чөлөөлөхгүй. Энэ тохиолдолд шүүгчийг үндэслэлтэйгээр татгалзан гаргах нь хэргийг хэлэлцэх хугацааг хойшлуулах, ажлын ачааллыг дахин хуваарилах, хэргийг хянан шийдвэрлэх хугацааг зөрчиж, эцсийн шүүхийн эрх мэдлийг дордуулахад хүргэж байгаа тул шүүгч, түүнийг татгалзах үндэслэл үүсэхээс урьдчилан сэргийлж, шүүх хуралдааныг явуулах үүргийг хүлээнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулах хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд шүүгч эдгээр иргэд, хуулийн этгээдийн хоорондын хэргийг шийдвэрлэхдээ иргэд, түүнчлэн хуулийн этгээдийн төлөөлөгчидтэй биечлэн харилцахаас зайлсхийх ёстой. Шүүгч эдгээр хүмүүст шүүхийн үйл ажиллагааны талаар зөвлөгөө өгөх, хууль зүйн зөвлөгөө өгөх эрхгүй”*** байдаг байна.

Шүүгчийг татгалзан гаргах асуудлыг ОХУ-ын ИПХ-ийн 19-өөс 21 дүгээр зүйлд, ЭПХ-ийн 61-ээс 65 дугаар зүйлд тус тус зохицуулжээ. Мөн түүнчлэн ОХУ-ын Улсын Дээд шүүхийн 2007 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 27 дугаар тогтоолд дурдсанаар “шүүгчийг татгалзан гаргах үндэслэлтэй холбоотойгоор шүүгч хэргийг хянан шийдвэрлэхдээ иргэдтэй эелдэг, бодитой, шударга хандах үүрэгтэй” гэсэн бөгөөд энэхүү үүргийг хэрэгжүүлэхийн тулд хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүгчээс татгалзах үндэслэлүүдээс аль болох

<sup>41</sup> Мөн тэнд, Эшлэл 40, 102 дахь тал.

<sup>42</sup> <https://aprp.msaf.ru/jour/article/view/15/16>, (Сүүлд үзсэн: 2022.11.21).

<sup>43</sup> <https://www.ugpr.ru/news/5955-advokaty-smogut-poluchat-posobie-po-bolnichnym>, (Сүүлд үзсэн: 2022.11.21).

<sup>44</sup> <https://rq.ru/documents/2007/06/08/sud-doc.html>, (Сүүлд үзсэн: 2022.11.21).

урьдчилан сэргийлж, шүүх хуралдааныг хэвийн явуулах үүргийг чухалчлан үзэж, хэргийн оролцогчидтой биечлэн харилцахаас зайлсхийх ёстой хэмээжээ.

Улмаар ИПХ болон ЭПХ-д заасны дагуу эрх зүйн харилцааны шинжээс хамааран хэргийн оролцогч буюу субъект нь өөр хоорондоо ялгаатай байх бөгөөд харин шүүгчийг татгалзан гарах үндэслэл нь зарим зохицуулалтын хувьд төстэй байдлаар зохицуулагджээ. Жишээ нь: Иргэний хэргийн субъектын хувьд эвлэрүүлэн зуучлагч хамаарна, харин Эрүүгийн хэрэгт мөрдөн байцаагч хамаарах зэргээр хэрэгт оролцож буй субъектээрээ ялгаатай байна.

Адил, төстэй зохицуулалтын хувьд авч үзвэл тухайн иргэний хэрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хоёуланд нь хэргийн оролцогч этгээдүүдийн аль нэг нь шүүгчтэй холбоотой ойрын хамаатан, төрөл садан нь байгаа бол тухайн хэргийг шүүгч шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн үндэслэлийг тус тус хуульчилж өгсөн. Харин **“хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал”** гэх үндэслэл нь зөвхөн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүгчийг татгалзан гаргах үндэслэл болж хуульчлагдсан.

Танхимын нийт шүүгчдээс татгалзах тохиолдлыг ИХХША-д “шүүх бүрэлдэхүүнээс бүхэлд нь татгалзах тохиолдолд тухайн хэргийг өөр шүүгч эсхүл өөр шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүхээр хянан хэлэлцдэг” байна. Харин ЭХХША-д “Хэд хэдэн шүүгчид, эсхүл шүүхийн нийт бүрэлдэхүүнд гаргасан татгалзлыг тухайн шүүх нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ” хэмээн тус тус хуульчилжээ.

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд иргэний болон эрүүгийн хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “шүүгчийг татгалзан гаргах”-тай холбоотой бусад гадаад улсын эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Ингэхдээ эрх зүйн тогтолцооны баялаг түүхэн хөгжилтэй, эрх зүйн системийн шалгуураараа боловсронгуйд тооцогддог орнуудыг сонгон судлахыг зорьж иргэнлэг эрх зүйн тогтолцооны томоохон төлөөлөгч болох ХБНГУ, Япон Улс, БНСУ, БНЛУ, ОХУ-г сонгон авсны дээр нийтлэг эрх зүйн бүлд харьяалагддаг АНУ-ыг мөн сонгон авч харьцуулсан болно.

Дээр дурдсан улсуудын ИПХ болон ЭПХ-ийн “шүүгчийг татгалзан гаргах”-тай холбоотой эрх зүйн зохицуулалт, түүний агуулга, хүрээ хязгаарыг судалсны үндсэнд дараах дүгнэлтийг хийлээ:

1. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах онцлог нь “шүүгчийг татгалзан гаргах” ойлголтоос салангид зүйл биш төдийгүй шүүгч нь тангараг өргөсөн, үйл ажиллагаандаа нийтлэг байдлаар хараат бус, зарчимч, шударга байх, төвийг сахих гэсэн зарчмыг ямагт баримтлан ажиллах үүрэгтэй субъект юм. Иймдээ ч шүүгчийн ёс зүйн харилцааг зохицуулсан үндэсний эрх зүйн хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээ болон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан зохицуулалт ч мөн байдаг байна. Жишээлбэл: Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйл, Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын Зарчим г.м
2. Монгол Улсын хууль тогтоомжид, тухайлбал ИХШХШТХ болон ЭХХШТХ-ын зохицуулалтад “шүүгчийг татгалзан гаргах үндэслэл”-ийг тоочих байдлаар тусган хуульчилсан (ИХШХШТХ-ийн 91 дүгээр зүйл, ЭХХШТХ-ийн 10.1, 10.2, 10.4 дүгээр зүйл). Тус үндэслэлд нийтлэг байдлаар “шүүгч тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах

эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал, хувийн сонирхолтой бол” гэсэн агуулга бүхий заалт тусгагдсан байна.

3. Энэхүү “үндэслэл бүхий эргэлзээ” гэдэгт юуг ойлгох талаар Бангалорын Зарчмын тайлбарт дэлгэрэнгүй тусгаагүй ч гагцхүү “үндэслэл бүхий шалтгаангүйгээр ... шүүгчийг татгалзан гаргаж болохгүй” гэж зохицуулжээ.
4. Дээрх шүүгчийг татгалзан гаргахтай холбоотой асуудлын хүрээнд бусад улсын эрх зүйн зохицуулалт болон түүнийг хэрэгжүүлж, тайлбарлаж буй шүүхийн практик сонгон авсан улсуудад ямар байгааг тоймловол:
  - ХБНГУ-ын хувьд шүүгчийг татгалзан гаргах асуудлыг ИПХ болон ЭПХ-даа ихээхэн төсөөтэй байдлаар хуульчилсан. Тухайлбал, “шүүгчийг гаргах (Ausschluss)” үндэслэл болон шүүгч хэргийн талаар өрөөсгөл ойлголттой байна гэсэн айдастай байх (fear of bias) тохиолдолд “шүүгчээс татгалзах” боломжийг хуульчилж өгсөн ба тус хоёр ойлголт нь агуулгын хувьд бие биеэ нөхдөг. Тус улсад нийтлэг байдлаар шүүгчийг гаргах, татгалзах дээрх үндэслэлүүдийг “аль болох явцуу хүрээнд” тайлбарлах нь зүйтэй гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, шүүгчээс татгалзах объектив үндэслэл байхыг шаарддаг.
  - Япон Улсад шүүгчийг татгалзан гаргах асуудлыг ИПХ болон ЭПХ-даа төсөөтэй байдлаар зохицуулжээ. Тодруулбал, шүүгчийг гаргах (除斥) үндэслэлүүдийг жагсаан хуульчилсны зэрэгцээ түүнийг нөхөх үүднээс шүүгчийн шударга, хараат бус байдалд эргэлзээ төрөхүйц тохиолдолд шүүгчээс татгалзах (忌避) ерөнхий үндэслэлийг хуульчилсан байна. Шүүгчийг гаргах болон шүүгчээс татгалзах явдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулах, үр ашиггүй зардал бий болгох сөрөг үр дагавартай байдаг тул, дээрх үндэслэлүүдийг аль болох явцуу хүрээнд, хязгаартайгаар тайлбарлах нь зүйтэй гэж судлаачид болон шүүхийн практикт үздэг байна. Ялангуяа, шүүгчээс татгалзах үндэслэлд шүүгч хэргийг хараат бусаар шийдвэрлэж чадахгүй гэсэн талуудын таамаглал бус объектив үндэслэл байхыг шаарддаг төдийгүй ямар ч үндэслэлгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулах үүднээс шүүгчийг гаргах, татгалзах хүсэлт гарсан тохиолдолд шүүгчээс татгалзах хүсэлтийг урвуулан ашиглаж байна гэж үзээд тухайн хүсэлтийг хэрэгсэхгүй болгох хууль зүйн боломжийг хуульчилж өгсөн онцлогтой байна.
  - БНСУ-ын эрх зүйн зохицуулалтын онцлог нь иргэний болон эрүүгийн эрх зүйн салбарын онцлогтой уялдан харилцан адилгүй байх боловч нийтлэг байдлаар “үндэслэл бүхий эргэлзээ” байгаа тохиолдолд шүүгчийг татгалзан гаргахаар тусгаснаараа Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай төсөөтэй байна. БНСУ-ын ИПХ-ийн зохицуулалтын хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад шүүгчээс татгалзах хүсэлт гаргаагүй бол дахин татгалзах хүсэлт гаргах эрхээ алддаг, харин ЭПХ-ийн зохицуулалтын хүрээнд ийнхүү шүүгчийн татгалзан гаргах хүсэлт гаргасан нь цаг хугацаа ихээр зарлагдах буюу шүүхэд хиймлээр ачаалал үүсгэхүйц гэж үзвэл хүсэлтийг хүлээж авдаггүй нь сонирхол татахуйц зохицуулалт байлаа.
  - АНУ-ын хувьд шүүгчийг татгалзан гаргах үндэслэлийн нэгд “үндэслэл бүхий эргэлзээ байвал” гэснийг тооцохоор байна. Түүнчлэн тус улсын муж бүрд энэ нь

харьцангуй ялгаатай байж болох ба жишээ нь: Виржиниа мужид Хуульчдад ёс зүйн зөвлөгөө өгдөг хороо ажилладаг. Шүүгчид өөрт нь тухайн тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах ёстой эсэх, шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үнэхээр үүссэн эсэх, шүүгчийн ёс зүйн зөрчил болох эсэх талаар эргэлзээ төрж, өөрөө түүнийгээ шийдвэрлэж тодорхойлж чадахгүй байгаа тохиолдолд энэ асуудлыг шийдвэрлэдэг дээрх хороонд хандах боломж олгосон.

- БНЛУ-ын эрх зүйн зохицуулалтын хувьд бусад улстай харьцуулахад процессын хуульдаа нэг шүүхийн шүүгч болон бүх шүүгч нараас татгалзан гарах хүсэлт гаргасан тохиолдолд хэрхэх талаар зохицуулсан байх ба шүүгч өөрөө татгалзан гарах болон хэргийн оролцогчийн зүгээс хүсэлт гаргах замаар татгалзах талаар зохицуулсан. Ийнхүү нэг болон хэд хэдэн шүүгчээс зэрэг татгалзсан бол тухайн хэргийг шийдвэрлэх боломжтой ижил түвшний өөр шүүхэд шилжүүлэхээр зохицуулсан. Шүүгчийг татгалзан гаргах нийтлэг үндэслэл нь тухайн маргаанд “шууд болон шууд бусаар ашиг сонирхолтой байх” юм.
  - ОХУ-ын хууль тогтоомжид шүүгчийг татгалзан гаргах үндэслэлд “шүүгчийг бодитой, шударга байдалд эргэлзэж буй нөхцөл байвал” хамаарахаар хуульчилжээ. Үүнээс гадна процессын хуульд шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх талаар дэлгэрэнгүй зохицуулсан байх ба хэргийг шийдвэрлэх шүүхийн шүүгч нарыг бүгдийг татгалзан гаргасан тохиолдолд тухайн хэргийг шилжүүлэх талаар зохицуулалт тусгасан нь сайшаалтай болжээ гэж үзлээ.
5. Дээрхээс дүгнэн үзвэл, шүүгчийн татгалзан гаргах талаар дэлхийн бусад улс ч мөн Монгол Улсын адилаар процессын хуульдаа тоочих байдлаар тусгасан байдаг нийтлэг тал байна гэж үзлээ. Мөн шүүгчийг татгалзан гаргах үндэслэлийг аль болох явцуу утгаар, хязгаарлагдмал хүрээнд тайлбарладаг нь шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, цаг хугацааг хэмнэх, зардлыг багасгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үндэслэлгүйгээр сунжруулахгүй байхтай нягт холбоотой байна.

## ЭХ СУРВАЛЖ

### Хууль тогтоомж, дүрэм, олон улсын эрх зүйн баримт бичиг:

1. Монгол Улсын Үндсэн Хууль.
2. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
5. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм.
6. Шүүгчийн ёс зүйн дүрэм.

### Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Шүүгчийн ёс зүй (сургалтын гарын авлага), Шүүхийн Ерөнхий Зөвлөл, 2018 он.
2. Шүүгчийн Ёс Зүйн Талаарх Бангалорын Зарчим (2002), Түүний Тайлбар (2007), *НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба*.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй (гарын авлага), 2007 он.
4. Sigmund A. Cohn, *Judicial Recusation in the Federal Republic of Germany*. 1973.
5. Peter Mezei & Emircan Karabuga, *Judicial Recusation in Germany and Turkey*. 2019.
6. Model Code of Judicial Conduct - American Bar Association
7. 伊藤眞『民事訴訟法』104頁(有斐閣 第6版 2018年)
8. 池田修=前田雅英『刑事訴訟法講義』290頁(東京大学出版会 第6版 2018年)
9. 伊藤・前掲注(1) 106頁
10. 新堂幸司『新民事訴訟法』87頁(弘文堂 第6版 2019年)

### Гадаад улсын шүүхийн шийдвэр:

1. Judgment of March 3, 1966 (BVerfG), *Neue Juristische Wochenschrift* 922 (1966).
2. Judgment of July 9, 1953, 4 BGHSt. 264.
3. Judgment of July 4, 1957 (BGHZ), [1957] NJW 1400 (W. Ger. 1957).

### Цахим эх сурвалж:

1. <https://www.mqlbar.mn>
2. <https://www.americanbar.org>
3. <http://khamtdaa.mn>
4. <https://rq.ru/documents/2007/06/08/sud-doc.html>
5. <https://www.ugpr.ru/news/5955-advokaty-smogut-poluchat-posobie-po-bolnichnym>
6. <https://aprp.msal.ru/jour/article/view/15/16>
7. <https://doi.org/10.37399/2686-9241.2021.1.113-127>
8. <http://www.consultant.ru/>
9. <https://likumi.lv/ta/en/en/id/107820-criminal-procedure-law>  
<https://likumi.lv/ta/en/en/id/50500-civil-procedure-law>